

Эрх чөлөөний дүүр

ПЭТӨФИ ШАНДОР

(1823-1849)

Улаанбаатар хот
2023 он

ННА 84.5
ДАА 808.81

Эрх чөлөөний дуурь

ПЭТӨФИ ШАНДОР



MINISTRY OF
FOREIGN AFFAIRS AND TRADE
OF HUNGARY

Petőfi
Cultural
Agency



Supported by:

Foundation for Hungarian Culture

Ивээн тэтгэсэн:

Унгарын соёлын сан

Эрхлэн гаргасан: Унгарын Элчин сайдын яам

Монгол хэлнээ хөрвүүлсэн: Чонос овогт Баатарын Энхтөр
Монголын Зохиолчдын Эвлэлийн болон “Г.Сэр-Одын нэрэмжит” шагналт
яруу найрагч, ОХУ-ын М.Ю.Лермонтовын нэрэмжит шагналт яруу найрагч,
Монголын Зохиолчдын Эвлэлийн Яруу найргийн Үндэсний Төвийн тэргүүлэгч
гишүүн, Говьсүмбэр аймгийн Соёл урлагийн газрын дарга

Хянан тохиолдуулсан:

Г.Хишигбадам, Унгарын Элчин сайдын Нарийн бичгийн дарга

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Дизайнер Т.Бат

“Хүслийн онго” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-9372-9-4

Улаанбаатар хот 2023 он

АГУУЛГА

Өмнөтгөл	5
Шүлэг мөнхийн тавилан	7
Нэгдүгээр бүлэг. Чонос овогт Баатарын Энхтөрийн орос хэлнээс монгол хэлнээ буулгасан шүлгүүд	9
Харих замын бодол	10
Уй гуниг-цалгим далай юм	10
Миний хайр	11
Эцэг эхдээ	12
Миний мөргөл	13
Зуны тэнгэрт үүлс тэнүүчлээд	14
Ахиад л намар, ахиад л догдлол	15
Амрагийнхаа тухай бодох агшинд	17
Унгар үндэстэн минь	18
Шуугих ой-өөрийн шувуудын жиргээтэй	20
Цэцэгс	21
Хайр гэж юу сан билээ	23
Уулнаа суугаад ажихуй	24
Тиса мөрөн	25
Шөнөөр зүүдлэгдсэн дайн	28
Зуун удаа хайр зүс нь хувиравч	29
Нэгэн шүүмжлэгчид	30
Унгар минь ээ	32
Үндэсний дуун	32
Баатарлаг дуун	34
Эх орондоо	36
Хайртай би	38
Өрөвтас	39
Алфельд	44
Ойд	46
Дахиад л дээр минь болжмор	48
Зүрх	50
Хаварт чи дуртай	51
Улжих намрын өдрүүдэд	52
Эзгүй газрын эл хуль замаар	53
Голын эх	54



Хоёрдугаар бүлэг. Б.Ринчин, С.Доржпалам, Д.Гомбожав,	
Ц.Хасбаатар нарын монгол хэлнээ хөрвүүлсэн шүлгүүд.....	55
Монголын уран зохиолд Пэтофи Шандор яруу найрагчийн тухай	56
<i>Б.Ринчиний орчуулга Амьд явах, үхэх хоёр</i>	60
<i>Б.Ринчиний орчуулга Эх орны төлөө согтоно</i>	61
<i>Б.Ринчиний орчуулга Ажилч Яанош</i>	62
<i>Б.Ринчиний орчуулга Интоорын жимс,</i>	
мөчрөөс нь сайн чимхдэг байлаа	63
<i>Б.Ринчиний орчуулга Зальтай архич</i>	64
<i>Б.Ринчиний орчуулга Яагаад</i>	65
<i>Б.Ринчиний орчуулга Аавын санаагаар бол</i>	66
<i>Б.Ринчиний орчуулга Миний муу шүлгийн учир</i>	67
<i>Б.Ринчиний орчуулга Кавош Яаношийн авгайн альбомд</i>	68
<i>Б.Ринчиний орчуулга Цаг ондоо болжээ, хорвоод</i>	69
<i>Б.Ринчиний орчуулга Хүний амь гэдэг чинь</i>	69
<i>Б.Ринчиний орчуулга Ард түмэн</i>	70
<i>Б.Ринчиний орчуулга Янаг амраг, эрх чөлөө</i>	71
<i>Б.Ринчиний орчуулга Нажкааройд</i>	72
<i>Б.Ринчиний орчуулга Эр хүн бол, эр хүн шиг бай</i>	73
<i>Б.Ринчиний орчуулга Шүүгч нар, шүүгч нар</i>	75
<i>С.Доржпаламын орчуулга Ганцхан эвгүй бодол</i>	
сэтгэлийг минь түгшээх юм	76
<i>С.Доржпаламын орчуулга Гэгээн дайныг би хүсэж байна</i>	78
<i>С.Доржпаламын орчуулга Чонын дуу</i>	79
<i>С.Доржпаламын орчуулга Хайртай би</i>	80
<i>Д.Гомбожавын орчуулга Мартаж чадахгүй нь</i>	83
<i>Д.Гомбожавын орчуулга Намайг хүн болгон найрагч гэж ярих юм</i>	88
<i>Д.Гомбожавын орчуулга Санаж байна уу?</i>	88
<i>Д.Гомбожавын орчуулга Салж мордохдоо хэлсэн үг</i>	89
<i>Д.Гомбожавын орчуулга Шалго</i>	91
<i>Ц.Хасбаатарын орчуулга Намрын хуучаар</i>	113
<i>Ц.Хасбаатарын орчуулга Өнө сайхан эх орон минь</i>	
Өндийн босох цаг боллоо	114
<i>Ц.Хасбаатарын орчуулга Нохойн дуу</i>	116
<i>Ц.Хасбаатарын орчуулга 1848 оны гуравдугаар сарын 15</i>	117

ӨМНӨТГӨЛ

Унгарчууд бид энэ 2023 онд Унгарын их найрагч Петөфи Шандорын (1823-1849) мэндэлсний 200 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэ хүрээнд түүний дурсгалд зориулан уянгын яруу найргийн бүтээлүүдийг нь багтаасан шүлгийн номыг хэвлүүлэн гаргаж байна. Унгарын их найрагчийн нэрийг Монголд мэдэхгүй хүн байхгүй гэж болно. Нэлээд олон зохиолч, яруу найрагчид түүний бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлсний дотор Унгарт докторын зэрэг хамгаалсан Б.Ринчин гуай “Эрх чөлөө, хайр дурлал” хэмээх алдарт шүлэг, “Зоригт Яанош” нэртэй жүжгийн туульсыг нь орчуулан, Монголын уншигч олонд толилуулсан. Энэ удаад түүний 200 жилийн ойд зориулан яруу найрагч, орчуулагч Б.Энхтөрийн орос хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн шүлгүүдийг өмнө орчуулагдсан шүлгүүдтэй хамтатган хэвлүүлэн гаргаж байна.

Богинохон амьдралынхаа туршид Петөфи Шандор явуулын жүжигчин, багш, орчуулагч, сонины эрхлэгчийн ажилд өөрийгөө сорьж байжээ. Тэрээр 1844 оны 11-р сард анхны шүлгийн номоо хэвлүүлэн гаргасан даруйдаа л алдар нэр нь үндэстэн даяар цуурайтан түгсэн юм. Харин таван жилийн дараа буюу 1849 оны 7-р сарын эцэст Шегешварын мөргөлдөөний үеэр тэр алга болжээ. Энэ богинохон хугацаанд тэрээр 850 гаруй шүлэг бичсэн бөгөөд түүний гэрэл гэгээтэй бүтээлүүдтэй дүйцэхүйц зохиол дэлхийн уран зохиолд ч цөөхөн гэж хэлж болохоор байдаг. Тэрээр маш олон янзын сэдэв, төрлөөр эпиграмм, үргэлжилсэн үгийн баатарлаг туулиуд (“Зоригт Яанош”, “Нутгийн алхчин”, “Галзуу Иштуук”, “Элч”)–ыг туурвижээ. Петөфи Шандор хурц тод шүлэглэж байсан ч чөлөөт шүлгүүд түүнээс хол байгаагүй. Түүний шүлгийн хамгийн түгээмэл сэдэв нь хайр дурлал, эх оронч үзэл, гэр бүл, Унгарын үзэсгэлэнт байгаль, газар нутаг, хувьсгал, эрх чөлөөний тэмцэл байв. Тэрээр Унгарын хээр тал нутгийг алдаршуулж, Олфөлд нутгийг яруу найргийн дүрслэлээр тод томруун үзүүлсэн нь Унгарын уран зохиолыг баяжуулжээ.

Түүний амьдралын чухал үе бол 1848-1849 оны хувьсгал, тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэл юм. 1848 оны үед болсон гадаадын хувьсгалууд их найрагчид маш хүчтэй нөлөөлсөн бөгөөд 3-р сарын 13-нд Венад гарсан хувьсгалыг мэдээд Пешт хотод бас хувьсгал хийх хэрэгтэйг ойлгосон байна. Ингээд 3-р сарын 14-нд нөхдийнхөө хамт Унгарчуудын хүсч буй үндсэн шаардлагуудыг 12 зүйлд багтаан



эмхэлж, түүндээ “Унгар үндэстэн юу хүсч байна вэ?” хэмээх нэр өгчээ.

Петөфи Шандор 3-р сарын 15-ны өдрийн Пештийн хувьсгалд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд “Үндэсний сүлд дуу”-ныхаа шүлгийг уншсан тэр цагаас хойш Унгарчуудын хамгийн алдартай бүтээлүүдийн нэг болжээ. Тэрээр шүлгүүддээ Унгар эх орноо чөлөөлөх тухай төдийгүй бүх хүн төрөлхтнийг зовлонгоос гэтэлгэх тухай бичиж байжээ. Магадгүй энэ бүх нийтлэг үзэл санаа нь түүнийг дэлхий даяар алдаршуулсан байх. Петөфи Шандор эрх чөлөөний төлөө, тэр байтугай хайрын төлөө бүх зүйлийг золиослох ёстой гэдэгт итгэлтэй байв. Гадаад ертөнцөд хамгийн их алдаршсан “Эрх чөлөө, хайр дурлал” шүлэгтээ энэ тухай өгүүлсэн байдаг.

Тэр зөвхөн шүлэг бичээд зогсохгүй эрх чөлөөний төлөө амиа өгөхөд бэлэн байгаагаа баталж, өөрөө гартаа зэвсэг барин тулалдахаар цэрэгт явжээ. Петөфи Шандор 1849 оны 7-р сарын 31-нд Унгарын цэргүүд Австри, Оросын холбооны цэргүүдийн эсрэг тулалдаж байх үед Шегешварын тулалдааны талбарт 26 насандаа баатарлагаар амиа алдсан гэдэг цуу яриа олон түмний дунд тархсан байсан. Хэдийгээр их найрагч алга болсон боловч цогцос нь олдоогүй тул тэр үеийнхэн болон эхнэр нь хүртэл түүнийг дайны талбарт нас барсан гэдэгт итгэхгүй байсан. Харин 19-р зуунд их найрагч Оросын талд олзлогдсон байх магадлалтай гэсэн мэдээ тархаж эхэлжээ. Петөфи Шандорыг Оросын цэргүүд Байгаль нуурын эрэг дэх Баргузин руу цөлсөн байж болзошгүй тухай мэдээлэл 1970-аад оноос гарч байсан. Одоо олон судлаач энэ сэдвээр судалгаа хийж байна.

Петөфи Шандорын бүтээлүүд нь Унгарын үе үеийн зохиолч, яруу найрагчдад урам зориг өгч, уран бүтээлийн онгодыг нь дэмжин сэргээдэг тул шүтэн бишрэгчид нь өнөөдрийг хүртэл түүний бүтээл туурвилын өв уламжлалыг үргэлжлүүлсээр иржээ. Их найрагч маань дэлхий дахинаа их алдар цуутай, түүний яруу найргийн боть нь дэлхийн олон оронд хэвлэгдэн гарахын зэрэгцээ түүнд зориулсан гэрэлт хөшөө, дурсгалт газруудыг байгуулсан байна.

Монголын олон нийт, уран бүтээлчид ч мөн адил Петөфи Шандорын яруу найргийг шимтэн уншингаа түүний дэвшилтэт сэтгэлгээ, эх орноо гэсэн халуун сэтгэлтэй нь танилцсанаар энэхүү Унгарын их яруу найрагч Монголын утга зохиолд зохих байр суурь эзэлнэ гэдэгт итгэлтэй байна.

Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна




ШҮЛЭГ МӨНХИЙН ТАВИЛАН...

Цаг хугацааны алсаас ч шүлэг нь тодорсоор гэрэлтэгч жинхэнэ яруу найрагч байна гэдэг жирийн бус эгэлгүй тавилан. Аливаа ард түмэн бүхэнд үеийн үедээ хайрлан хүндлэгддэг, өөрсдийн бахархалт яруу найрагчид байдаг. Тэдний нэг нь эх орон, ард түмнийхээ төлөө яруу шүлгээ өргөн, амь биеэ үл хайрлан тэмцсэн, үнэний дууч Унгарын суу алдарт найрагч Пэтөфи Шандор бөлгөө.

Хэл яриа, зүс, амьдарсан цаг хугацаа өөр хэдий ч хэн хэнийхээ шүлгийг уншаад уран бүтээлийг нь мэдэрч ойлгодог нь магадгүй, яруу найрагчдын хувьд билэгт номын тохиол буй за. Унгарууд буюу мажарууд бол Монголчуудтай угсаа, үндэс нэгтэй, хөх толботой, Хүннү гүрний хойчис. Пэтөфи Шандорын шүлгүүдийг уншихад эгээ л эрх чөлөөний төлөө эр зоригоороо дүрэлзэн дүүлэн давхих эрэмгий морьтон шиг санагдах бөлгөө. Яруу найрагчийн язгуур нандин чанар нь эх орон, ард түмнээ хайрлахад оршдог буюу.

Монголын тал нутгийн эгэл нэгэн шүлэгч би бээр Пэтөфи Шандорын зарим шүлгүүдийг оросоор олж уншаад эх хэлнээ зориглон хөрвүүлсэн нь хэдийвээр мөчид байж магад ч мөнхүү Монголын маань суу билэгт эрдэмтэн, соён гэгээрүүлэгч Б.Ринчин абугай хийгээд бусад нэрт орчуулагчдын орчуулсан шүлгэсийн номыг олж, энэхүү номынхоо нэгэн бүлэг болгон орууллаа. Ийнхүү их найрагч Пэтөфи Шандорын шүлгүүдийг ч орчуулж байсан нь манай монголчууд эртнээс мажар үндэстэнтэй сайн харилцаатай байж, мах цусны тасархай мэт хүндэлдэг байсныг нотлон бататгахыг зорьсон юм. Миний орчуулсан энэхүү шүлгүүдийг хэвлүүлэхээр болсонд Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, монголч эрдэмтэн хатагтай Др.Обрущанский Борбала танд гүнээ талархахын ялдамд Монгол, Унгар улсын найрамдалт харилцаанд оруулж буй үйлс, бүтээлд нь чинхүү бахархан баясдагаа дуулгасуу. Эрхэм Элчин



сайд та, Их эзэн Чингис хааны язгуурын Цагаан шонхор сүлдэт боржигин овгийн соёлын өлгий нутаг Говьсүмбэрт аймгийн Засаг дарга Г.Батзамын урилгаар албан айлчлал хийж, нийгэм соёлын олон талт ажлыг эхлүүлэх тухай найрсаг яриа хэлэлцээрийг өрнүүлсний учир, Мажарын суу их найрагч, ард түмнийхээ хайртай хүү Пэтөфи Шандорын шүлгүүдээр бүтсэн энэхүү номыг түмэн олноо өргөн барьж, найрамдлын замаа уртасгаж байгаа нь манай аймагт хийсэн айлчлалын тань машид сайшаалтай үр дүн юм.

Өдгөө цагт ч эрх чөлөөнийхөө төлөө цогтой тэмцэгч, яруу найрагч Пэтөфи Шандор шиг Унгарын зоригт хөвүүд, залуус хойчис нь их найрагчийнхаа бадрангуй шүлгийг уншин бахархдаг гэдэгт миний бие үл эргэлзэхийн учир хойшид эх зохилдлогот мажар хэлнээс нь монгол хэлнээ төгс билгүүнээр буулгах эрдэмтэд, орчуулагчид бий гэдэгт итгэнэм. Уншигч танаа дэлгэн барих их найрагчийн уянгын шүлгүүд нь монголоор орчуулагдсан нь үгүй учир, Пэтөфи Шандор нь зөвхөн эх орон, эрх чөлөөний дуулагч найрагч төдийгүй гүн мэдрэмжит сонгодог туурвилч, төгөлдөр авьяаст, байгалийн зөн өгөгдөлт, онгод билгүүн яруу найрагч байжээ гэдгийг өөрийн хэр чинээндээ тодотгохыг хичээсэн билээ.

Унгар үндэстнээ бахархан дуулсан суут яруу найрагч Пэтөфи Шандор таны алдрын өлмийд тал нутгийн шүлэгч би вээр гүнээ хүндэтгэн мэхийж, яруу тансаг шүлгийн тань шидэт галын дөлийг бууруулсан аваас уучлал хүсмой. Монгол, Мажар ард түмний мөнхийн бат найрамдлын залгамж ашид орших болтугай.

*Хүндэтгэсэн, **Чонос овогт Баатарын Энхтөр**
Монголын Зохиолчдын Эвлэлийн болон “Г.Сэр-Одын нэрэмжит” шагналт яруу найрагч, ОХУ-ын М.Ю.Лермонтовын нэрэмжит шагналт яруу найрагч, Монголын Зохиолчдын Эвлэлийн Яруу найргийн Үндэсний Төвийн тэргүүлэгч гишүүн, Говьсүмбэр аймгийн Соёл урлагийн газрын дарга*

2022.08.23. Чойр.



Дэгдүүлээр бүлэл

Чонос овогт Баатарын Энхтөрийн орос хэлнээс
монгол хэлнээ буулгасан шүлгүүд





ХАРИХ ЗАМЫН БОДОЛ

Олон жил уулзаагүй хайртай ижийдээ
Очихдоо би, юу гэж хэлэх билээ дээ.
Өлгийдөө сонссон - энхрий тэр үгсээс нь илүүг
Өнөөдөр би яаж олж хэлье дээ.
Хөсөг тэрэг минь эрчлэн давхих ч
Цаг хугацаа-яараагүй мэт санагдах
Хөөр баярын олон бодол
Хүүд нь хөврөн бодогдсоор байна даа.
Хаалгаа нээгээд орохуйд., Ижий минь өмнөөс!
Хоолойноос минь үг давсангүй ээ.
Ургийн модны мөчрийн навч шиг
Үр нь таныгаа чимээгүй тэвэрлээ.



УЙ ГУНИГ-ЦАЛГИМ ДАЛАЙ ЮМ

Уй гуниг - цалгим далай юм.
Аз жаргал - ёроолд нь буй сувд билээ.
Угтаа тэгээд - ээ золгүйхнээр ч,
Атгаж олтлоо бид тарчилсаар л явдаг юм.



МИНИЙ ХАЙР

Миний хайр-
Нартын тал нойрсох амгаланд
Нарны үнсэлт шиг улаан байдаг.
Аялгуут жиргээнээс нь зүүдээр сэрдэг.
Алтан гургалдайн жиргээ биш ээ.
Миний хайр –
Нам гүмхэн ойн цөөрмийн
Мөнгөн сарны цацрах тусгалд
Гангар хун гоёмсгоор сэлэх
Намжир төгс үзэмж биш ээ.
Миний хайр-
Өтгөн ойн даруухан байшин дахь
Өмнөө тавьсан амттан биш.
Ээжийн хайраар охиноо өсгөдөг
Эсэн амгалангийн ордон биш ээ.
Миний хайр-
Шигүү гүн харанхуй ойд
Ширвэх харцнаас ч чамайг харамласан
Ирт чинжаалаа атгаж зогсоо
Эрсэлсэн зоригт дээрэмчин юм.



ЭЦЭГ ЭХДЭЭ

Ээ дээ, эцэг эх минь,
Эд баялагтай байсан бол доо,
Элдэв зүйлээр гачигдалгүй
Энх мөнх жаргах байсан даа.
Хүссэнийг чинь хүү нь биелүүлээд л
Дугагдахыг үзэхгүй амьдрах байсан даа.
Дарс нь дундардаггүй зоорьтой
Гэрэл гийсэн байшинд минь
Анд нөхөд нь аавынд минь зочлоод
Ай, баяслын далайд умбаад л,
Сүм явах ижийдээ би
Сүйх тэрэг хөлөглүүлээд л,
Залбирлын номны хавтсанд нь
Алтаар товойлгон урласан
Царай нь гэрэлтсэн Есүс харагдаад л,
Аргамаг сайн хүлгүүдийн
Аль сайныг нь хураагаад л
Худалдаа яармагийг зорин
Хөвүүд дүү нар минь унаад л,
Хамаг олон гайхсан
Дүүрэн номын сантай
Хэдэн мөнгөөр үнэлдэггүй
Дуурсах шүлгүүдээ тэрлээд л,
Шүлгийнхээ төлөө зоос нэхэлгүй
Хэвлэлийн албатуудыг алмайруулаад л
Хүмүүст түүнийгээ бэлэглээд
Хичнээн бахтай явах сан даа.
Хүүгийн чинь гэргий яах аргагүй
Хүүхэн хонгор Мажаар бүсгүй байна даа.
Хуримын ёслолдоо хөөрөлдөн баясаад
Хүсэл дүүрэн халуунаар бүжээд л,
Эд хөрөнгөтэй байсан бол доо
Ингээд л хүү нь амьдрах сан уу.
Ээ дээ, эцэг эх минь,
Эсвэл хүү нь баян болох уу!



МИНИЙ МӨРГӨЛ

Ээж минь, намайг нүгэл үйлдэх вий гэж үргэлж айдаг сан, -
Эвий дээ, шалтгаангүйгээр бүү ай гэж би хэлдэг сэн.
“Бурханд залбир, сүмд оч” гэж
Бууралхан ижий минь зөвлөдөг байв.
Тиймээс би залбирч байна аа: энд, ээжээ.
Энгэртээ гараа зөрүүлж,
Ихээр догдлон чичирч, эмээж байнам.
Дэлхийн эзэн минь ээ, өнөөдөр намайг сонс.
Тэнгэрийн хүчнүүдийн хаан, намайг сонсооч!
Нэгдүгээрт... тийм ээ!
Нэгдүгээрт, миний хувьд Эх орон минь шүү дээ.
Ай, хүчирхэг бурхан минь ээ,
Ай, түүнээс илүүг би яахин гуйж чадах вэ?
Эх оронд минь овоорсон зовлон зүдгүүрээс
Эгнэгт салгаж өгөөч л гэж гуйнам!
Тэнгэрлэг хүчнүүдийн хаан! сонсооч гуйж байна.
Тэмцэлд дуудаж эх орныг минь авраач!
Өөрийнхөө төлөө юу гуйх билээ дээ?
Өнгөлөг сайхан найз бүсгүй хүсч байна гэх үү.
Амаа мэдэхгүй давхих аранзал морь шиг
Алдрын титмүүдээр булагдахыг хүсэх үү.
Титмээр би яах ч билээ дээ.
Тэрүүгээр морьдоо л өвс шиг хооллоно доо.
Тэмцэлд дуудаж эх орныг минь авраач!
Тэнгэрийн хүчнүүдийн хаан, намайг сонсооч!





ЗУНЫ ТЭНГЭРТ ҮҮЛС ТЭНҮҮЧЛЭЭД

Зуны тэнгэрт үүлс тэнүүчлээд
Зүс төрх нь үргэлж өөрчлөгдөнө.
Сарнин нүүх нь яг л бидний
Санаа бодол, хүсэл мэт ээ.
Цаг хугацаанд үүлсийг хэн хөлөглөдөг билээ.
Цаанаас нь тэднийг хэн илгээнэм билээ?
Цэхлэн түлхэх цаг хугацаа
Чиглэх зүг нь үүрд урагшаа билээ.
Аянга цахилгаан, аадар цутгах мэт
Амраглал хайр, хүсэл тэмүүллийн үүлс-
Аль ч цагийн таагүй уй гунигт өдрүүд,
Алсарч салаад явдаггүй.
Андлал нөхөрлөлийн хэлхээ үүлс –
Энэг нарны туяа хэсэг гялсхийх зуур,
Эх дэлхий баясгалангаар инээмсэглэх ч
Агаарын хувирал хоромхоноо өөрчлөгдөж
Ахиад үүлс тэнгэрийг бүрхэнэ.
Хар ч бай, цагаан ч бай үүлс
Хар сүүдрээр нөмөрч хучдаг билээ.
Нимгэн ч бай, зузаан ч бай үүлс
Нилэнхүйдээ тэнгэрийг хөшиглөдөг билээ.
Халуун нарны гялбах хурц туяанаас
Ханалан хамгаалах үүлс минь
Үлгэр домгийн ордон мэт
Үзэсгэлэн төгөлдөр байдаг аа.
Андлал болоод амраглалын үүлс
Аясаар туугдан алсад одовч харин,
Үдийн цономол наранд ч
Үүлс байсаар л байх болно шүү гэж
Сүүлчийн мөчид орондоо байхдаа би,
Сүсэгт ламыг дуудаад хэлсүү.



АХИАД Л НАМАР, АХИАД Л ДОГДЛОЛ

Амьдралын минь агшин бүрийг чимэн будах
Ахиад л намар, ахиад л догдлол
Хайрлахын шалтгаанаа эс оловч., би түүнийг
Хайрласаар, дахин хайрласаар л байнам.

Унах навчсын чимээгүйхэн үглээнийг
Суун сонсох намрын анирт
Өвсний налуугаас уудмыг ширтэн
Мэлмий живүүлэх гүнд ууснам.

Өлмий дээрээ зөөлхнөөр гишгэлэн ижий минь ирээд
Унтах үрсээ эвийлэн энхрийлэх шиг
Нарны туяаны нөөлөг инээмсэглэл
Намрын өнгөөр орчлонг хулдана.

Бөмбөрцөг минь, чи үхээгүй шүү!
Бүүвэйлэгдэн зүүдэлж байгаа биш үү.
Амгалан нойрондоо аятай умбанхан
Амарч байгаа юм биш үү.

Орныхоо дэргэдээ нямбайханаар
Гоёлынхоо даашинзыг эвхэж тавьчихаад
Одоохон гээд өмсөхөд бэлэн
Гоодох цагтаа бэлэн байна уу.





Айсуй хаврын эхний өдөр хүртэл
Амарч нойрс доо, үзэсгэлэнт байгаль минь,
Наашилж буй тэр өдрийг иртэл
Нандин гэгээн зүүдээр бялхаарай.

Хурууныхаа өндгөөр эвийлэн
Хүндэт шүлгийг тэрлэхүй
Хөнгөн гунигийн эгшиглэн
Хөлгүй мартагдахын хязгаарт дуурсав.

Намрын усны яралжинд замхрах
Салхины шивнэх сүүлчийн үгсийг
Надтай хамт чимээгүй сонсон
Сэрүүхэнд хамт суу, найзхан минь.

Үнсэлдье гэвэл хоёулаа
Уруул уруулаараа л мэдэрч хүрэлцэн
Унтаж буй бөмбөн моддыг
Үүрэглэх нойрноос нь сэрээчихгүй л юм шүү.



АМРАГИЙНХАА ТУХАЙ БОДОХ АГШИНД

Амрагийнхаа тухай бодох агшныг
Алагхан цэцэгстэй зүйрлэм билээ.
Амьсгал догдлон энэхэн цэцэгсээ
Арчлан тордож ургуулнам билээ.
Цусаа дуустал урсаад наран жаргах шиг
Цул уулс нил ягаан, нил ягаан өнгөтэй,
Цугтаа нь үгүй чиний минь буй алс тэртээд
Цувих манан ч нил ягаан зүстэй.
Зүүнээс мандах наран хаяран жаргатаг
Зөрүүдэлж би дорнын тэнгэрээр алхахгүй байсан даа.
Зүгээр л, умраас сөрөн дорныг хүртэл
Зүйрлэшгүй сайхан алсын чамдаа зорих сон доо.
Хөөрхөн чамайгаа харснаас болов уу
Хөөр баярын хувцсаа өмссөн шиг
Өнөө шөнийн одод
Өнгөлгөөр гэрэлтэх нь гоёмсог бас эрх дураараа.
Өө, сайхан чамайгаа харахаараа би
Өчүүхэн ч атугай ойртоод суухаараа
Мэлмийг чинь ширтэн нүдээ тас аниад
Миний долоо дахь тэнгэр минь! гэж шивнэнэм.





УНГАР ҮНДЭСТЭН МИНЬ

Бурхны бүтээсэн энэ дэлхийгээс
Бүхий л даяар улсын дундаас
Мажар үндэстэнтэй эн зэрэгцэхийг
Магад олохгүй билээ.
Өрөвдөх үү, үзэн ядах уу?
Өнөөдөр чамайг хянгардаж шүүмжлэх үү.
Сэтгэл сэргээж, нүд баясгах “амттан”
Цэцэрлэгт сайхан нутагтай билээ.
Ээрэм далайд алт эрдэнэсээ тараах шиг
Эгнэшгүй амин тариа будаагаа цацаж
Эд баялгаа! Салхинд хийсгэх чинь
Ээ дээ, нүд чинь сохорч, чих чинь дүлийрэв үү?
Зүүдэндээ ч төсөөлж үзэхгүй
Зүйрлэшгүй их өгөөмөр эрдэнэс
Уул, нутгийн минь хэвлийд байнам.
Ухаарч үүнийг ойлгож байна уу.
Өөдгүй баячуудын талбайн барлаг болж
Өнчирсөн хүүхдүүд шиг өлөн зэлмэгхэн
Өлсгөлөн, доромжлолыг тэвчиж, ард түмэн минь
Өөрсдөө юунд сүйрэл рүүгээ алхана вэ.
Мэргэдийн ухааны жинхэнэ сувд
Миний ард түмний сэтгэлд нуугдаж,
Өтгөн түнэр харанхуйгаас
Өөдөө гаргаж дээшээ аваачна даа.
Өнөөдөр хэнбугай ч үл сэхээрэх аваас
Өөрсдөө л харин ул мөргүй шаварт живнэ дээ.
Харь хэлтний боол болж
Харийн нутагт очиж ажиллах
Хатуу гашуун хувь тавилан
Харин эсвэл хүлээж байгаа даа.

Хэрвээ тэр үед чиний цусыг
Хэн бэ? гэх үндэстний чинь дуудлага сэрээхэд
Харамсалтай нь, бүх зүйл хэдийнэ
Хашгирч бачимдавч оройтсон байх вий дээ.
Ичгүүрт доромжлолтой энэ байдлаа
Эрхэмсэг бардамнал чинь жигшихийн цагт
Хэн хэнийгээ дэмий л зүхээд
Хэмлэлдэж хоорондоо нүдэлдэх вий дээ.
Мянган мянганаар суурьшин амьдарсан
Мажаар үндэстний нутаг минь билээ.
Магад доройтохын энэ цагт ч
Мартаж болохгүй бардамнал зүрх сэтгэлд бий.
Одоо бид сураггүй болбол
Олон жилийн дараа хэн нэгэн
Агуу мажаарууд энд байсан уу гэж
Асуувал тэгээд юу гэх сэн билээ.
Өрнөх дэлхийн ирэх хөгжилд
Өнөөдрийн бидний тухай асуувал
Өвөг түүхийн хуудасны мөрүүд
Өөрийн чинь тухай юу гэх сэн билээ.
Түүхийн хуудсанд бидний тухай:
“Тисагийн хөндийд зуунаар суурьшсан
Түүхт энэ овог, үндэстнийхэн
Арчаагүй хулчгар, залхуугаасаа болоод
Арчигдаж сөнөсөн” гэж хүүрнэвэл яах вэ.
Эх орон! минь бидэндээ одоо л
Эр зоригийн цацраг түгээ,
Зэвэрсэн мананг нэвтлэн гэрэлтэх
Зорилго бахархалт алдрын гялбаа хайрла!





ШУУГИХ ОЙ-ӨӨРИЙН ШУВУУДЫН ЖИРГЭЭТЭЙ

Шуугих ой - өөрийн шувуудын жиргээтэй
Нуга цэцэрлэг - өөрийн зүлэгтэй
Цэнхэр тэнгэр - өөрийн одтой
Цэмцгэр залуу - өөрийн амрагтай.

Нуга цэцэглэж, ногоолзой жиргэнэ.
Нээлхий тэнгэртэй, бүсгүй цэнгэнэ.
Дөрвүүл хөтлөлцсөөр алсыг зорино.
Дунгуй орчлонд зам хоршино.

Цэцэгс гандана, одод харвана.
Цэнхэртэх алсыг шувууд зорино.
Цээжний амраг ханьтайгаа л
Цэнгэлт орчлонд - он жилүүдийг дүүргэнэ.



ЦЭЦЭГС

Өтгөн ширэг өвстэй талбай дахь
Өнгөт мандалт цэцэгсийг хараад
Өө дөө цэцэгс минь, цэцэгс минь хэмээн
Өөрийн эрхгүй үзэсгэлэнг тань биширнэм.

Хөөрхөн хонгор үзэмжинд чинь
Хөвүүд, охид шиг баяснам.
Цаг нь ирвээс булшин дээр минь
Цэцэг тариарай гэж гэрээсэлнэм, би.

Энхрий цэцэг минь дэргэд чинь суугаад
Элдвийг хөөрөлдөн дулаацуулмаар байнам.
Энэрэх хайрыг минь цэцэг чи мэдэрнэ үү.
Эргээд хэлэх хариуг чинь догдлон хүлээнэм.

Цэцэг чи хэлснийг минь ойлгосон доо.
Чимээгүй тэгээд юунд ичингүйрнэ вэ!
Цаг нь ирвээс булшин дээр минь
Цэцэг тариарай гэж гэрээсэлнэм, би.





Ээ дээ, үнэр чинь -үг шүү дээ.
Эргэн тойронд цэцэгс дуулахыг сонсном.
Авсанд хэвтэхийн цагт минь
Аялгуут энэ дуу бүрхэхийг мэдэрнэм.

Сүүлчийн удаа би сүнстэйгээ
Мөрөөдлийнхөө хөгжмийг сонсохоо мэднэм.
Цаг нь ирвээс булшин дээр минь
Цэцэг тариарай гэж гэрээсэлнэм, би.

Сүнсийг минь амирлаасан энэ дууг
Совин зөнгөөрөө сонсох болно оо.
Бүүвэйн дуу шиг намуун аялгуунд
Бүтэн нойрсож унтах болно оо.

Хучлага цасыг хайлуулан
Хаврын уринаар сэрэх болно оо.
Цаг нь ирвээс булшин дээр минь
Цэцэг тариарай гэж гэрээсэлнэм, би.

ХАЙР ГЭЖ ЮУ САН БИЛЭЭ

Нулимсаар дүүрэн усны эргүүлэгт
Хөнгөн завь шиг хэврэгхэнээр даялан
Уйтгар гуниг минь залуурын ард зогсном.
Уйлан хагацах мэт дарвуул нь дэрвэгнэнэ.
Хад чулуугаар зүрх бүтдэггүй!
Хайр гэж миний хувьд юу сан билээ?

Хар муухайг далдалсан түнэрт
Сарьсан багваахайн исгэрэл шиг,
Харанхуй ой, багир шугуйд
Сүрэг чоно аймшигтай улих шиг
Хад чулуугаар зүрх бүтдэггүй!
Хайр гэж миний хувьд юу сан билээ?

Усны эрвээхэйг хөөн гүйж
Нисдэг цэцэг гэж андуурах гэнэн хүү
Урдаа байгаа гүн нүхэнд
Унахаас айхгүй дэгдэн харайх шиг
Хад чулуугаар зүрх бүтдэггүй!
Хайр гэж миний хувьд юу сан билээ?

Мөрөөдлийн цаазлагч минь намайг
Мөрнөөс өргөөд хөтлөн явах шиг
Сэтгэл минь шоронгийн хаалганы цаана
Цогцос минь тавцан дээр хэвтэх шиг
Хад чулуугаар зүрх бүтдэггүй!
Хайр гэж миний хувьд юу сан билээ?

Өргөс дүүрэн цэцэгт бутан дээгүүр
Өр зүрхээрээ гишгэлэн алхах шиг
Аянга цахилсан аадрын дараа
Ариусаад ахиад тэмүүлэх шиг
Хад чулуугаар зүрх бүтдэггүй!
Хайр гэж миний хувьд юу сан билээ?



УУЛНАА СУУГААД АЖИХУЙ...

Өндөр уулын орой дээр
Өрөвтас шувуу мэт суунам би.
Хөгжөөнгүй өнгөрүүлсэн жилүүд шиг минь
Хормой хэжин гол урснам.
Уй гашуудлаа барьж тэвчихгүйнэм.
Усан нүдэлж эргэн тойронд далай болвол
Үзсэн амьдралын аз жаргал гэвээс дунд нь
Өчүүхнээр торойх арал байхсан даа.
Уудам хөндий, хээр тал, уулын хэцэд
Уйсган намрын чийгтэй салхин үлээнэм.
Үхэж буй зун, хүйтэн салхины жихүүдэс
Үймээнт ийм л намрын улиралд дуртай би.
Шаагилдах шувууд мөчирс дээр жиргэхгүй.
Шаргалхан навчис сэрчигнэн тасрах агшинд
Унах навчсын гараас нь хөтлөөд
Уруугаа хамтдаа үсэрчихмээр байнам.
Эргэлдэн эргэлдэн газарт унах навчистай
Ижилдэн би эргэлдэн унаж үхмээр байна!
Үхсэнийхээ дараа эргээд төрвөл
Үзэсгэлэн төгөлдөр шугуй болж ургамаар байна!
Ертөнцийн мунхаглал, доромжлолоос нуугдаж
Ерөөсөө би ойн шугуй болж ургамаар байна.
Түүнээс ч илүү гал болж дүрэлзээд
Түмэнтээ намайг залхаахгүй болтол нь
Түймэрдэж бүхнийг шатаамаар байна!



ТИСА МӨРӨН

Үдшийн бүрэнхий газарт хөшиглөв.
Өмнүүр минь Тиса мөрөн чимээгүйхэн цалгина.
Эжийдээ яарах эрххэн хүү шиг
Эрэмгий цовоогоор давалгаа ханална.

Элэгдсэн эргийг эмжээрлэн урсах
Энгүй өргөн тунгалаг мөрнийг
Нарны туяа ч нэвтэлж чадахгүй
Нарийн нэхээсээр хөөсрөн хээлнэ.

Мөрний гадаргуу үелзэн бүжээд
Дагинас дуулах шиг найрлаар эгшиглэн
Үл үзэгдэх найрал дуутай хоршин
Давалгаа жингэнэн давирах мэт ээ.

Алтан хивс дэлгэн дэвссэн мэт
Алаг дэлхийг шаргалхан өвс хулдаад
Агуу уудам хөндийд тариан түрүү
Авралт номын мөрүүд шиг жирийнэ.

Ахиад цаашилбал, сүр жавхлантай, түнэр,
Аглаг харанхуйд бүрхэгдсэн ой унтана.
Үүрийн туяа гийх нь час улаан өнгөтэй титэм шиг,
Үлэмжийн царс модноос цус урсаж байгаа мэт ээ.

Эрэгт ургасан залуухан бургас, нарс
Эргэлдэн урсах ус руу тонгойн тольдоход
Холдон ойртох саглагархан оройн завсраар
Холын тосгоны дүрс ганжирлан бүрэлзэнэ.





Алтан насны гэгээн дурсамж шиг
Алсад үүлс хөвж, тэнгэр цэлмэв.
Марморош уулнаас тээр цагт над руу ширтсэн
Мартахын аргагүй нүд манан дунд гэрэлтэв.

Чимээгүй нөмөрч. Ус хөлдөв.
Зөвхөн шувууд л хаяадаа исгэрэх мэт сонсогдов.
Нугын салхин тээрэм зогсолтгүй эргэлдэн
Шумуул дүнгэнэх шиг чимээ чахрав.

Тосгоны зүгээс нөгөө эрэгт
Домботой бүсгүй хүрч ирээд
Усгал нүдээрээ над руу харчихаад
Усаа авчихаад хурдан буцав.

Хав газарт гинжлэгдсэн мэт
Харанхуйд би хөдөлсөнгүй.
Багил усыг чимээгүй ширтэн
Байгалийн сайханд мансууран хэвтэв.

Байгаль минь, чиний хүүрнэх хэлтэй
Бидний хэл хэрхэн эн зэрэгцэх билээ дээ.
Чимээгүй байх чинь хүртэл, юутай сонголонт
Чимэгт айзмын гайхамшиг хөгжимлөг билээ дээ.

Тосгонд би шөнөөр очин,
Түүдгийн дэргэд жимсээр дайлуулав.
Халамжит нөхөдтэйгөө сэтгэлийн яриа өрнүүлээд
Халуун нөөлгөнд нь гишүү шатан төөнөж хонов.

“Анд нөхөд минь-надад хэлээч
Ачит Тиса юугаар та нарыг яаж гомдоосон юм бэ?
Дэлхийн хаанаас ч хайгаад олохгүй
Дөлгөөн хүлцэнгүй мөрөн шүү дээ” гэлээ.

Үүнээс гурван хоногийн дараа
Үүрийн гэгээнээр аюулын харанга дуулдав.
“Сүйдлээ!, сэтэрлээ!, гамшиг!, гамшиг!” гэх хашгираан
Гүйгээд харвал цэлэлзэх тэнгис мэлтэлзэж байв.

Дарлалын гинжнээс мултарсан Тиса мөрөн
Далан хаалтуудыг цөмөлж сэт цохиод
Асгаран цалгиж хязгааргүйг эзлэхээр
Аймшиггүй зоримогоор давалгаалж байлаа.



ШӨНӨӨР ЗҮҮДЛЭГДСЭН ДАЙН

Эртний өвгөдийн минь дуудлага шиг-
Эр зоригийн цустай илд бариад
Их тулаанд мажааруудыг дуудсан
Ийм дайныг шөнөөр би зүүдлэв.
Эрхэм сэлмийг хараад бүгд босож,
Эрсэлсэн зориг судсаар халуу дүүгэн гүйхэд;
Жингэнэх зоос бидний амины төлбөр биш -
Жинхэнэ эрх чөлөө л бидний эцсийн зорилго юм.
Энэ амьдралд нэг тохиох хуримын өдөр байсан тэр шөнө
Ээ дээ, хайрт минь, бидний хурим яах вэ!
Эх орныхоо төлөө галд унахаас эмээлгүй
Эхний шөнө дунд гэрээсээ гарсан би.
Хуримын анхны шөнө үхлийн зүг явна гэдэг
Хувь заяаны аймшигтай сугалааны шодолт! гэвч,
Тэр шөнийн зүүдний дайны төлөө
Тэмцэлт тулалдаанд би явах болно, хайрт минь итгэ.



ЗУУН УДАА ХАЙР ЗҮС НЬ ХУВИРАВЧ

Тэмүүлэн урсдаг хүслийн галзуу голыг минь
Тэврэн угаагаач арал минь, хайр минь,
Зуун удаа би чамайг өөрөөр харж байнам.
Өхөөрдөм, сайхны чинь төлөө
Өндөр ханыг чинь өгсөөд
Өврийн бүхнээ дэлгэн мацах шиг
Өргөл залбирлыг минь сонсох ариун сүм шиг байнам.
Аль хэнд ч гоо сайхнаа дээрэмдүүлэхэд бэлэн
Аялагч баян шиг чамайг төсөөлнөм.
Гэнэт хайр минь тоосноос жижигхэнд хувираад
Гэмшил эрэн гуйлгачны өмнө сөхрөх шиг харагднам.
Өндөр оргилт Карпатыг нөмрөх, өтгөн үүл болном.
Өр зүрх минь аянга цахилгаан шиг цохилсоор, даруй
Өнгөт сарнайн бут болон хувирахад чинь
Өөр дээр чинь эргэлдэн алтан гургалдай шиг дуулнам.
Өөрчлөгдөх араншинтай ч, хайрлах минь буурахгүй.
Өнө мөнхөд амьд байнам.
Гол шиг нам гүм чимээгүй урсавч
Гүн ёроолд нь хэн ч хүрч олохгүй оршном!





НЭГЭН ШҮҮМЖЛЭГЧИД

Эрхэм ээ! Таны мэдэж байгаагаар
Этгээд нэгэн муу зан надад бий:
Эзэн ба эгэл хэнбугайд ч
Эгцэлж үнэнийг нүд рүү нь шиддэг!

Эрхэм ээ! та тэнгэр бурхан биш
Эргэлзэлгүй мэдэж ав, аварга биетэн ч биш, -
Яагаад үнэн хэрэгтэй байна вэ? гэдгийг
Ямагт шууд хэлж болохгүй гэж үү?

Эрхэм ээ! Цээжинд чинь байх ёстой
Чин авьяаст яруу найрагчийн сүнс чамд алга!
Хөөрлийн сансарт хөвөн шиг хийсээд
Хөнгөн магтаалын хийрхэлд цадсан байна!

Эрхэм ээ! Хөвөн гэрэлтдэггүй.
Хөвөнгөөс оч гарахгүй,
Хөвөнгөөс цахисан цахиур чулуу байдаггүй.
Хөх дөл хэзээ ч үсрэхгүй.

Эрхэм ээ! Хэрвээ би мэддэг сэн бол
Энд чи эргэлдэх хэрэггүй,
Алиа салбадай биш - ажлаа орхи гэж хэлэх сэн!
Эрхэм ээ! Миний мэдэхээр аав чинь
Кечкемет дахь сүүлчийн гуталчин ...
Аавынхаа хөдөлмөрийг хүүхдүүд нь залгамжилж
Ачлалтай ажил хийхийг хүсэхгүй байна уу?!



УНГАР МИНЬ ЭЭ

Эрхэм хүндэт эх орон танд минь
Энэ гэрийн тань “эзэгтэй” зохихгүй байна:
Ёроолдоо өм халуунаар шатаж,
Өнгө нүүрэндээ - түүхийрсэн байна.

Аз жаргалтай хэдэн хүмүүс элбэг дэлбэг
Авлигадаж цадахгүй идсээр байна.
Ард түмэн - хөөрхий хүүхдүүд чинь
Амь тавин өлсөж үхэж байна!





ҮНДЭСНИЙ ДУУН

Бос, мажаар! Эх орон чинь дуудаж байна!
Бүүр оройтоогүй шүү: Сонголтоо хий.
Боолын тавилантай эвлэрэх эсвэл
Бүхнээс Эрх чөлөөтэй байх эсэхээ шийд!
Бурхны өмнө Унгарууд тангараглана.
Хэзээд-
Боолын тавилантай эвлэрэхгүй.
Хэзээ ч-
Өнөөдөр бид амьдарч ахуйгаа
Өвгөдийнхөө өмнө юу гэж хариулах билээ!
Эрх чөлөөт өвгөдийн минь сүнс
Энэ боолын газарт амрахгүй ээ.
Бурхны өмнө Унгарууд тангараглана.
Хэзээд-
Боолын тавилантай эвлэрэхгүй.
Хэзээ ч-
Гинжинд баглуулснаас, хоёр дахин илүү
Гартаа барьсан бидний илд гялалзах болтугай.
Гав зүүж алхах билүү, бид
Ган сэлмүүдээ ярсхийн өргөх болтугай.
Бурхны өмнө Унгарууд тангараглана.
Хэзээд-
Боолын тавилантай эвлэрэхгүй.
Хэзээ ч-
Өнө эртнээс суу алдартай
Унгарын нэр бадартугай.
Түмэнтээ дуудуулах шившгээ арилгаж!
Тулалдааны өмнө бүгд тангараглая.
Бурхны өмнө Унгарууд тангараглана.
Хэзээд-

Боолын тавилантай эвлэрэхгүй.
Хэзээ ч-
Эрсэдсэн газар минь - тэнд бунхан босгог.
Ирэх цагт ач, үрс минь мөргөг.
Хожмын үедээ гэгээнээр дуурсах
Хойчийн үрс минь нэрсийг минь бүү умартаг.
Бурхны өмнө Унгарууд тангараглана.
Хэзээд-
Боолын тавилантай эвлэрэхгүй.
Хэзээ ч-





БААТАРЛАГ ДУУН

Бие болоод сэтгэлээрээ
Чинийх шүү, Эх орон минь
Чамайг хайрласан шигээ хэнийг хайрлах вэ!
Чамдаа хайртай - Эх орон минь!

Сэтгэл минь - өндөр сүм юм!
Сэтгэлээ хэрвээ өгөхийг хүсвэл
Өндөр сүмээ би шатаагаад
Өөрт чинь өгөх болно оо, Эх орон минь!

Үнс туурин болсон цээжнээс минь
Өргөх мөргөл минь ниснэ ээ.
“Эх орныг минь ивээтүгэй!” гэх
Эцсийн гуйлт минь сонсогдоно оо.

Нарт ертөнцөд эх орон минь
Нандин бүхний дээд юм шүү гэж
Чангаар би хашгирахгүй
Цээжиндээ батад мөргөсөөр явнам.

Сүүдэрт чинь нуугдаж
Сүнс мэт алхахгүй би,
Баяраар гэрэлтэх цагт чинь ч
Балагт хүнд үед чинь ч хамт байх болно!
Гэгээн өдөр улам бүүдийж

Гэрэлгүй харанхуй нөмрөн өтгөрсөөр л
Улс эх орон чинийхээ төлөө зовнин
Уйтгарлан гуних минь нэмэгдсээр л.

Уй гунигаа дарахад минь
Урдах хундага минь нөхөр болно.
Хундаганы цаанаас эх орны минь
Хувь заяаны гэгээ мандах болтугай.

Гал шиг халуун дарсыг
Ганц ч дусал үлдээлгүй тогтооно оо.
Энэ хундаганд мэлтэлзэх дарс
Эх орон чиний төлөө нулимс юм шүү!





ЭХ ОРОНДОО

Алтан буудай найгах тал нутгийн дайдад,
Аагим зуны халуунд ч манан татдаг газарт
Амин дурсамжит эртний зургууд тодорно!
Ай даа, намайг хар даа! Таньж байна уу? Би чиний хүү!

Улиасны төглийн доороос ширтэн
Урагшаа нисэх тогоруудыг аждаг сан.
Ром үсгийн тавын тоо шиг шувуудын цуваа
Өмнийг зорин өвөлжихөөр нисдэг сэн.

Төрсөн гэрээсээ тээр өглөө гарахад
Тэвэрч хүүгээ үдсэн салалтын үгсийг
Хөөрхий эжийн минь ерөөлийн адислалтай
Хуйлрах салхин шивнэсээр үдсэн сэн.

Он жилүүд шинээр төрж, цаг хугацаа улирч,
Олон олон жилийг тэнгэрийн замд нь үджээ.
Насыг хөтөлсөн хувь заяаны тэргэнцэрт суугаад
Нарт хорвоог би эгээрэн тойрч амжжээ.

Асгарсан хөлсөөрөө дулааныг нь мэдэрсэн
Амьдралын сайхан сургууль – Бурхны гэгээт хувь заяа,
Ангам цөлийн чулуунд ч хөл нүцгэнээр
Айсуй зам нь өргөстэй ч зориглон туулсан сан.

Үхэл шиг гашуун хэцүү хатуу тавиланг
Үзсэний хувьд би хэнээс ч илүү мэднэ.
Шаналал гэдгийг шанагаар нь уусан болохоор
Шархалсан сэтгэл хэдийн дассан даа.

Улирсан жилүүдийн зовлон зүдгүүр
Уй гуниг минь одоо арилах ёстой.
Ул мөргүй бүхнийг мартахаар зорин ирлээ.
Үүрдийн жаргалын нулимсаар нүүрээ угаах ёстой.

Ээвэр нар нь хүүгээ гэж таниад
Инээмсэглэн туяарах нь үлэмж дотно.
Ээж минь үрээ хөхүүлж өсгөсөн
Эрдэнэт газар өөр хаана билээ?



ХАЙРТАЙ БИ..

Хайртай би, хэн нэгэн шиг биш
Хачин этгээд ч байж магадгүй.
Хайрлахын тухай төсөөллөөс чинь
Хамаагүй ондоо бий нь мадаггүй.
Хөөгдөж цөлөгдсөн-Охин тэнгэр минь
Хөөрхийлж чамайг энэрч хайрланам.
Зүйргүй ихээр хайрлавч -Эрх чөлөө минь
Зүүдэнд минь байх нь мөрөөдөл юм.
Зүүдэндээ л би дандаа учранхан
Зүрхний чамтайгаа уулзах юм.
Цэцэгт нугад өнөө шөнө
Цээжний үгээ шивнэж хоносон юм.
Өмнө чинь сөхрөөд, эрх чөлөө минь
Өр сэтгэлийн бүхнээ илчилсэн юм.
Өнгөт цэцгийг өөрт чинь өгөхөөр
Өвдгөө бохирон бөхийсөн юм.
Гэтэгч алуурчин цаазлагч араас минь
Гэнэт толгойг минь тас цавчихад -
Эрх чөлөө чамдаа өргөх цэцгийн оронд
Эрсдэн бөхийж би толгойгоо өгөв.




ӨРӨВТАС

Өнгө хулдан хуурдаг
Өөр өөрийн өнгөтэй, олон шувууд орчлонд байдаг.
Гайхам хоолойтой магад зарим нь
Ганган зүстэй бусад олон нь гэвч,
Гоо сайхнаараа гэрэлтүүлдэггүй: Өрөвтас минь л
Хагас нь цагаан, хагас нь хар
Харц нь над шиг, зүс нь энгийн.

Миний гайхалтай өрөвтас минь!
Уугуул тал нутгийн минь чимэг
Өрөвлөг жигүүртэй хүүхдүүд минь
Өрөвтасыг хайрладаг амин учир минь
Өлгийтэй нялхаас минь хамтдаа л
Өөртэй минь өссөн болоод ч тэр үү,
Жигүүртэн найзуудын чинь дундаас
Жигтэйхэн илүү чамд хайртай шүү.

Өрөвтас минь надтай...,
Өнгөрсөн амьдралын минь бүхнийг хуваалцсан
Зуны ногоон талбайд тоглоход минь
Зугаатай хөгжөөнтэй чимээ гаргагч минь
Ядарсан хөвүүд оройдоо сүргээ тосгон руу туухад
Ямагт хөөцөлдөн тоглодог найз минь,
Зэгсэн дотроос үүрний чинь зүг ширтээд,
Зэрмийсэн дэгдээхэйнүүддээ ирэхийг чинь аждаг сан.
Өдлөх үрсээ тэжээхийн төлөө хоол зөөж ирэхийг чинь хараад
Өрөвдөж л суудаг байлаа даа, би.





Өтгөн манан шиг богинохон чөлөөт завандаа:
Өнгөт орчлонг би бодоод амждагсан.
Яагаад, хүмүүн бид далавчгүй болоод
Яллагдсан мэт газраар мөлхөнө вэ?
Өргөн дэлхийн хаана ч гэлээ
Өөрсдөө хүрч чадах хөлтэй шүү дээ,
Газар тэнгэрийн аль ч хязгаарт
Гарцаагүй хүрэх сэн гэх мөрөөдөл минь сэрдэг сэн.


Нар руу нисч, уудам цэлмүүнд цойлон гараад
Номин цэнхэр талбайг эгц дээрээс нь харахсан
Гэрлээр сүлжсэн сийрсэн малгай шиг,
Гэрэлтэх дэлхий минь ай үзэсгэлэнтэй юу,
Эцсийн дусал цусаа дуустал тэмцсээр нар улайран
Ээрэм шөнийн харанхуйд идэгдэхийг хараад,
Ээ дээ, хүмүүст гэрэл гэгээ авчирдаг бүхэн ингээд
Эцэст нь үхэх тавилантай юу хэмээн боддог сон.

Усан үзмийн багц, амтат жимсээр дүүрэн сагстай
Урдаас ирээд ижий минь
Үрсээ дайлах шиг
Урин зочломтгой намрыг хүүхдүүд тэсэн ядан хүлээдэг байлаа.
Анд сайн өрөвтас минь, энэ үед
Алс холын тэнгисийг зорин нисэхэд!
Арвин их бэлгээр ч би одоо яах билээ гэж
Анх удаа есдүгээр сарыг зэнзийрхэн бодсон сон.

Хаашаа зорих нь үл мэдэгдэх
Хашгиран ганганасаар өрөвтас сүргээрээ нисэн одохыг хараад
Амьдрал, залуу насаа орхиод би
Алс үүрд явах мэт! санагдсан сан.
Бэхний толбо шиг үүрнүүд нь байшингийн дээвэр дээр үлдэхэд,
Би нулимсаа арчин тэднийг үдсэнсэн.
Хүүглэх салхины зөнч шивнээн дуулахдаа:
Хувь заяа чинь ийм байна! гэж надад хэлэхийг сонссон сон.

Цасан хүрмээ хөрст гэнэт тайлж
Цангинатал инээсээр хавар ирээд
Цэцгэн чимэгт, өвсөн ногоон даашинзаараа гоёход
Өө, миний сэтгэл баясаад
Өөрийн эрхгүй хөхүүн болдог сон.
Өрөвтас шувуугаа ирэхийг түрүүлж харах гээд
Өрөөнийхөө цонх руу гүйж хүрдэгсэн.

Алдрай нас өнгөрч, залуу нас минь
Аадар бороо шиг над дээр асгарч ирэв.
Алхах хөлөн доор минь газар шатах шиг омголон байв!
Аргамаг хүлэгтээ мордоод жолоо тавин
Агуу уудам талаараа ганцаараа эрх чөлөөтэй давхидаг байв.
Агсал жигүүрт хүлгийг минь гүйцэлгүй
Араас минь салхи өмдөндөө таварцаглаад хоцрох шиг
санагддаг сан.



Ай тал нутаг минь, би чамд хайртай!
Айлтгүй эрх чөлөө орон зай энд л бий.
Тавиун тал нутагт оюун санаа юунд ч баригддаггүй ээ.
Таашгүй харагдах байдал хязгаарлагдахгүй ээ.
Амьгүй хад чулууд шиг дүнсийгээд
Аймшигт цөллөгийн зүүд шиг надад дарамт болдоггүй.
Асгаран урсах хүрхрээ гав гинжний харжигнаан сануулах шиг
Ай даа, би тийм чимээ энд сонсдоггүй.

Тал нутаг таагүй гэв үү? Өө үгүй дээ, үзэсгэлэнтэй шүү.
Таньж мэдэх л хэрэгтэй.
Хөшигний цаадтайх ичсэн охин шиг
Хөөрхөн нүүрээ тэр нуудаг.
Өөртөө итгэсэн дотно нэгэндээ хөшгөө нээж
Өөрийнхөө энхрийнхэн нандиныг илчилдэг.
Шидэт гоо сайхныг нь хараад
Ширтээд ханашгүй бахдах болно оо.

Тал нутагтаа би хайртай!
Гал агсам хүлгээрээ туулан давхидаг сан.
Үхсэн ч хүний ул мөр олдохгүй уудамд,
Уухайлан давхисан тохиолын нэг удаа
Өтгөн өвслөг талын дундах нууранд
Өөрийн танилуудаа хараад цочих шиг болсон.
Өрөвтас шувууд өмнөөс минь ширтэхийг хараад
Өө, ямар гайхамшиг вэ? гэж дуун алдсан сан.

Танимхайран над руу нисэн ирсэн дээ..., өрөвтас минь,
Тал нутгаа хоёулаа хайрлах учиг үүссэн дээ.
Тээр нуурын гилмэн мандлыг санах бүрийд
Тал нутгаа мөрөөсөх минь ихэссэн дээ.
Өрөвтас минь бага, залуу настай минь салшгүй
Өө, тэр миний найз, ах минь байсан.
Өвөрмөц гоёхноор дуулдаггүй ч гэлээ
Өөрийнхөөрөө энгийнд нь би хайртай!

Өө, хайрт өрөвтас минь чи,
Өвөрт минь үлдсэн мартагдашгүй зүүдний минь бүх
эрдэнэс минь

Өвлийн улиралд явсан зүгийг чинь ширтээд
Өмнөөс “Шувууд ирэх цаг боллоо!” хэмээн бодохуй
Өрөвтас минь “Хурдан ирээрэй!” хэмээн залбирмуй.
Айсуй намраар найз минь чамдаа би дахин дахин
“Аян замдаа сайн яваарай!” хэмээн ерөөхийг хүсэж байнам.



АЛФЕЛЬД

Нарсаар бүрхэгдсэн Карпат минь!
Найрсаг романтизм чинь надад хэрэггүй.
Бахдавч чамайг, би хайрлаж чадахгүй.
Байнгын айлчин чинь биш, ховор зочин шүү.

Өөрчлөгдөшгүй Алфельд - миний нутаг
Өргөө гэртээ би хувь заяагаа эдэлдэг.
Ужиг тал хээрийн хязгааргүйг харж,
Уулын бүргэд шиг омголон эрх чөлөөтэй дүүлдэг.

Энгүй цэнхэрлэг үүлсийн дээрээс
Инээмсэглэн цэцэглэгч тал нутгаа хардаг.
Тиса мөрөн, Дунайн уудам хөндийд
Тариан талбай, бэлчээр нь налайж байдаг.

Хүзүүндээ хонхдойтой хүрэн үхэрнүүд
Талын зэрэглэнд тааваараа бэлчээрлэдэг.
Худгийн усанд цувран шуугилдаж
Тарган хонинууд майлалдан идээшилдэг.

Адуун сүрэг давхихуй. Салхин
Морьдын төвөргөөнөөр чимээлдэг.
Адуучид исгэрэлдэн шуугилдаж,
Алга ташилт шиг шилбүүрийн чимээ хөндийг сэрээдэг.

Тэврэх хүүхдээ энхрийлэн бүүвэйлэх шиг
Талбайн эрдэнэ шишийг салхин найгуулахад,
Хааяадаа тааралдах хөдөөх гацааны бараа
Хаяагүй тэнгис дэх бадмаараг эрдэнэ шиг харагддаг.

Нургих шувуудтай хаяа тэртээгээс
Нугас ниссээр оройдоо ирдэг.
Усны тохойд умбан байснаа дэрхийн үргэхүйд
Уялзах зэгс л туялзан найгадаг.

Холцорсон хана нь барайж халтартсан
Далиу яндантай дэн буудалд
Хурдан морьдын хазаар гүйлгэгчид хоолой норгон
Дараагийн яармагтаа яарамгүйхэн наргидаг.

Дэн буудлын амтаг гуа ургасан тарвасны талбайн
Дэргэдэх бургасанд харцага өндөглөөд
Дэггүй ноорхой багачуудаас хол байлгахаар
Дээгүүр нь харуулдаж байнга эргэлддэг.

Бургасны нөмөрлөгт хүйтэн сэрүүхэнд
Бут өвс сагсайн, тайжийн жинс цэцэглэдэг.
Тааваараа ээвэрлэж наранд хэвтсэн гүрвэлүүд,
Тармаг сөөгний доогуур нуугдан шургацгаадаг.

Тэнгэр, газар уусан уулздаг.
Тээр бүдэг, манан будант зураас
Сүмийн хонхнууд, жимсний цэцэрлэгүүд
Сүүмэг хөх мананд өндрөөс харагддаг.

Алфельд! Гайхамшигт сайхан миний төрсөн нутаг
Анх бүүвэйлсэн өөжин минь билээ.
Амьдрал эцэслэхэд намайг тэврэн хучих
Атга шорооны чинь төлөө би тэмцэх болно оо!



ОЙД

Шигүү гүн харанхуй
Царсан ойд тэнүүчлэхүй
Шигтгээ мэт цэцэгс даруухнаар
Содон гоёмсог алаглана.

Шувууд шулганан жиргэлдэж
Давирхайн үнэрт мансуурнам.
Шуугин жүнгэнэлдэгч зөгийд
Цэцэгс тойрон эргэлдэнэ.

Цэцэгс амьсгалах нь мэдэгдэхгүй
Цэх оргилууд чимээгүй
Шунгинах зөгийн чимээ
Шувуудын жиргээнд илбэдүүлнэм.

Агч, царс модод
Алгуур тавтай нойрсоно уу?
Моддын тэргүүн шиг би ч
Магад нойронд автсан байна уу.

Өндрөөс урсах усыг
Навчсын сиймхийгээр ажваас
Өргөн урсгал болоод
Гүйж хурдлахыг ширтнэм.

Хөвөгч үүлсийн араас
Хөнгөн сум шиг ниснэ.
Усны урсгал хурдлан
Улам тэмүүлэн цаашилна.

Алдрай багын зангаараа
Араас нь дагаад гүйх шиг минь,
Залуугийн мөрөөдлийнхөө хойноос
Завгүй хөөцөлдөн гүйсэн шиг минь,

Өмөг нөмрийн анирт
Өөрийгөө алхаж буйг мартнам.
Зөгий дүнгэнэх чимээнд
Зөөгхөн тайвшралыг олно.





ДАХИАД Л ДЭЭР МИНЬ БОЛЖМОР

Дахиад л дээр минь болжмор
Дассандаа, бидэн хэн хэндээ
Хаврын өдрүүдийн элч минь дуул,
Хязгааргүй тэнүүнд хаврын тухай дуул,
тайвшралыг.

Эрсдэх тулааны чимээ шуугианы дараа!
Ээ бурхан минь, юутай гэгээн эгшиглэн бэ.
Улайдсан гарын цусыг минь
Уянгалаг ариун хөгөөрөө угаанам билээ.

Дуул, хонгор минь, бүү зогс.
Дулаахан жиргээ чинь сэтгэл бүлээцүүлнэм.
Би зөвхөн эр цэрэг биш,
Билгийн зүгт яруу найрагч.

Уран жиргээ чинь цэнхэрлэнг бүрхнэм
Уран найраг хайрын төлөө.
Энгүй энэ хоёр Дара эхийн төлөө
Эгшиглэн цэнгэ, дураараа жиргэ.

Ялдамхнаар жиргэх дуунд чинь
Дутуухан нойр минь сэргээд
Ягаан сарнайн хоёр бут шиг
Дурсамж болоод мөрөөдөл цэцэглэнэм.

Мөрөөдлөө жигүүрлэн хайргаа зорин ниснэм.
Магадгүй аз жаргалд хязгаар үгүй биз ээ.
Хүсэл дүүрэн аз жаргалыг авчран
Хүн бүрт түгээхийг би хүснэм.

Тэнгэрт диваажин үгүйг
Тэндхийн бурхад надад шивнэв.
Аз жаргал гэдэг чинь
Алхах газарт хөлийн дор байнам.

Дуул, болжмор минь. Чи бол- дуудлага
Дуулим газарт цэцэгс дэлгэртэл дуул.
Хаврын элч минь, дуул, бүхнийг сэрээ.
Харанхуйн сүнсүүдийг унтах нойрноос нь сэргээ.



ЗҮРХ

Өвдөх зовлонгоороо түүнд өртэй болохоор
Өөрийн зүрхээ би сугалах болно.
Шигтгэж булсан газарт нь, Алдрын титэм ургаг.
Шийдэмгий зоригтон түүнийг олж автугай.
Эрх чөлөөний төлөө тулаанд орох
Эр зоригтон байх болтугай.



ХАВАРТ ЧИ ДУРТАЙ...

Хаварт чи дуртай, харин би-
Намар, үдэш, сүүдэрт дуртай.
Хаврын өдрүүд-чиний амьдрал
Намрын өдрүүд-харин минийх.

Хавар шиг чи-цэмцгэрхэн
Шинэхэн сарнай мэт дэлгэрхэн
Намрын гэгээ, миний дагуул
Намсан бөхөх тавилантай.

Цаашаа гэнэгүй алхаж боломгүй
Цагийн будан намайг хучна.
Цагаан үс шанханд минь нэмэгдэж
Цастай өвөл намайг угтана.

Би алхам ухраад чи урагшилбал
Бидний алхаа зэрэгцэх болно.
Гар гараасаа хөтлөлцөөд хамтдаа
Гал зуны цэцэрлэг рүү алхах болно.





УЛЖИХ НАМРЫН ӨДРҮҮДЭД

Улжих намрын уйман өдрүүдэд
Уйлагнуур наран манан дунд нуугдана.
Уйт зөөлөн бороо шиврээд
Үүлэрхэг, бүүдгэрхэн суунаглана.
Зайгүй холхи жихүүн өрөөг
Задгай зуух нь дулаацуулахгүй!

Цонх, хаалга хүйтэнд хучигдсан
Цаашилж гадагшаа гарах эрхгүй!
Задгай зуухны галын дэргэд
Зайчилж суугаад ээвэрлэнэ.
Сүүлчийн тарчлалын жилүүдээ
Зүгээр л үдэж бүлээцнэ.

Өнгөрсний дурсамжууд-овоолго юм!
Өвс мөчир шиг тэднийг тармуурдан аваад
Өнгөрсөн өдрүүдээ бөөгнүүлэн
Өрвөлзөх дөлтэй зуух руу бөөнөөр нь,
Өрөвдөх юмгүй гал руу хаянам.

Суунаглах хөх утаа.., хөх утаа
Сувдан нулимс шиг урсана.
Бороонд норсон
Нойтон мөчрийн ус биш шүү.
Бодол эгшээсэн
Зүрхний гуниг урсана уу.

Ээ дээ, энэхэн цагт дэргэд минь
Энхрийхэн чи минь байсан ч болоосой.
Тормойтол дуугүйхнээр инээмсэглээд
Торгон алчуураараа нүдийг минь арчих
байсан даа, дуугүйхнээр.



ЭЗГҮЙ ГАЗРЫН ЭЛ ХУЛЬ ЗАМААР

Эзгүй газрын эл хуль замаар алхахуй
Энд модгүй, бутгүй, өвсгүй
Алтан гургалдай жиргэх чимээгүй
Алс холын булш шиг цуурайтах газар.

Харанхуй түнэр үдэш нь үүлээр хувцасласан,
Хан хурмаст дээрх од үгүй мэт санагдах
Харанхуй тэнгэр үүлс нөмөрч хэвнэглэх шөнөөр
Харин би бор нүдэн харцыг санав –
Хайрлах амьдрал ирж, замдаа баяртай алхав,
Харагдснаар бүх зүйл байдаггүй -
Хачин орчлон шүү дээ.

Булш шиг замын хажуу цаахна
Бут бутаараа цэцэглэсэн сөөг, өвс, модод ургаад
Газрын ховилын цаана байгаа тэнгэрт
Гарагсын том одод тоолж барамгүй олон байх вий.





ГОЛЫН ЭХ

Хонхдой жингэнэх шиг хөгжимлөгөөр
Горхи баясгалантай урсдаг байлаа.
Хонгор насандаа сэтгэл минь баясгалантай
Горхи урсах шиг хөгжимлөг байсан даа.

Толин түлхүүр шиг чам дээр
Тэнгэрийн наран гялбаж байсан даа.
Эрхэс, саран долгионд нь умбаад
Энгэрийн зүрх загас шиг цовхчиж байлаа даа.

Бяцхан горхи урссаар өргөн гол болсон.
Бүгт намуухан амар амгалан үгүй болсон.
Сүм хийд шиг шөнө дундын одод
Шуугиант урсгалд чинь гялбахгүй болсон.

Тэнгэр минь, одоо нүүрээ буруул даа!
Тусгал дотор өөрийгөө танихгүй ээ.
Усны ёроол булингартсаныг мэдвэл
Урсгал яагаад бохирдсоныг ойлгоно оо.

Улаан цусан толботой гол
Урсан долгилох шалтгааныг мэдэв үү?
Дэгээнд хүчээр орсон загас
Дэвхцэн цовхорч амь тавьсныг ойлгов уу.



Хоёрдугаар бүлэг

Б.Ринчин, С.Доржпалам, Д.Гомбожав, Ц.Хасбаатар
нарын монгол хэлнээ хөрвүүлсэн шүлгүүд



МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛД ПЭТӨФИ ШАНДОР ЯРУУ НАЙРАГЧИЙН ТУХАЙ

Унгарын их шүлэгч Петөфи Шандор бол дөнгөж 27 хүрэхтэй үгүйтэй насалсан хүн. Энэ 27 жилийн долоон жилд нь шүлэг бичжээ. Петөфи 1823 оны нэгдүгээр сарын 1-нд төрөөд 1849 оны долдугаар сарын 31-нд хаант Оросын түрэмгий цэргийн эсрэг тулалдаж байгаад амь үрэгдсэн билээ. Шүлэгчийн төрсөн нутаг бол Унгарын Алфельд хэмээх газрын цэлгэр уудам тал дунд орших нэгэн бяцхан гацаа юм. Петөфийн эцэг эх хоёр нь уг нь славян гаралтай бөгөөд яваандаа мажааржсан байна. Петөфийн амь зууж байсан тэр үед нийгмийн давхаргад задрал гарч, ажилчин анги дөнгөж үүсэн бойжиж байв. Петөфи бол гарал үүсэл, хувь зохиолоороо хар борчуулын эгнээний хүн юм аа. Эцэг нь мал нядлагчийн туслагч байгаад дараа нь хөдөөгийн нэг махны мухлаг түрээслэн авчээ. Эх нь Пешт хотын Кирай гудамжны нэгэн баян айлд шивэгчин байв. Эдний амь зуулга нь үнэндээ ядуу зүдүү хөлс хүчээ гаргаж байж олсон жаахан юмаараа гэдсээ тэжээж байжээ. Петөфи эцгийнхээ замаар явсангүй эхлээд сургуульд ороод дунд сургуулиасаа гараад тэр үеийнхний ярьдгаар “замаа алдсан” хүн гарчээ. “Тэнэх хувьтай төрсөн хүн би, тэнэж явах нь миний заяа” гэж Петөфи бичсэн байдаг. Петөфи үнэхээр Унгар нутгийн тэн хагасыг явган голдуу тойрчээ. Гэдсээ тэжээхийн эрхээр үүргэвч үүрч бадарчилж явахдаа Петөфи борчуултай нөхөрлөж, тэднийхээ тухай шүлэг дуу бичдэг байсан. Эрдэм ном сурах гэж ултай сууж оролдоогүй ч гэсэн латин, герман, франц, англи хэл мэддэг байжээ. Эртний Ромын их шүлэгч Горацийн шүлгийг латин хэлээр уншдаг болжээ. Дараа нь Шекспир, Беранже, Шелли нарын зохиолоос унгар хэлээр хөрвүүлж ч үзсэн байна. Петөфи сайн дураараа цэрэгт мордож “жагсаалын цэргээс дээш гарсангүй”. Өвчин туссан учир Петөфийг цэргээс халжээ. Петөфи дахин хэсэж тоглодог жүжигчин ч болж үзжээ. Өл залгахын тулд хүний гар ноорог хуулах буюу ном зохиол орчуулж ч хэсэг

үзжээ. Харин ингэж явахдаа шүлгээ бичсээр л байв. Заримдаа хэд хоног, сараар найз, танилуудындаа “зочилдог” байв. Ингэж хэсэж явахдаа хөдөөгийн язгууртны охидод дурлаж, шүлэг, захиа бичиж заримтай нь толгой холбохыг оролдож байсан удаа ч бий. Тэр үеийн Унгарт тэнүүлч шүлэгч гэдэг маань тэнүүлч жүжи

гчнээс долоон дор үзэгддэг байжээ. Бүр хожим бүх орон даяар алдар нэр нь тарсан хойно л сая нэг хувцасны загвар сэтгүүлийн редакторын туслахаар ажиллах болов. Тэр сэтгүүл нь загвар-зураг хэвлэхийн зэрэгцээгээр уран хошин үгтэй тайлбар сэлт хэвлэдэг байв. Энэ үед тэр цагийн шүүмжлэгч нар хүртэл Петөфийн авьяас чадварыг үнэлэн үзэх болжээ. Гэлээ ч гэсэн язгууртын утга зохиолын нялуун амтанд хэтэрхий орчихсон хэсэг этгээдүүд Петөфийн шүлгийг “өөдгүй”, “бүдүүлэг” гэж зүхсээр байв. Хэдүйгээр Петөфийн авьяас билэг улам хөгжин бадарч байсан боловч хэдэн долоон хоног, сараас бусад бүх насаа ядуу зүдүүгийн байдлаар өнгөрөөжээ. Харин нас бараад олон жил болсны хойно утга зохиолын түүх судлагчид энэ тэнүүлчийг “цагаан болтол” угаахаар оролдсон боловч бүтээгүй билээ. Петөфийн шүлгээс хувьсгалт утга агуулгатай шүлгийн нь хасах зэргээр нилээн хичээсэн боловч тэр нь тус болсонгүй. “Петөфид хувьсгалч шүлэг байснаар барахгүй түүний бүх яруу найраг нь хувьсгалч юм аа” гэж Унгарын цогт хувьсгалч Бэла Кун хэлсэн. Петөфи өөрөө, миний шүлгийн хувьсгалт агуулгын үндэс бол миний гарал үүсэл, нийгмийн байдалтай холбоотой гэж бичсэн байдаг. Петөфи зөвхөн гарал үүслээрээ ядуу байсан болоод хувьсгалч болсон шүлэгч бишээ. Петөфи бол ухамсартай хувьсгалч мөн. Тэр цагийн хувьсгалт үзэл санааг шуналтайяа эзэмшиж байсан хүн билээ. “Миний ганц уншдаг, өглөө оройны уншлага болж өл залгах хоол болж байгаа юм бол Францын хувьсгалуудын түүх мөн” гэж 1848 оны 3-р сарын хувьсгал эхлээд гурав хоносны дараа өдрийнхөө тэмдэглэлд бичсэн байдаг. Петөфи бол туйлбартай ардач үзэлтэй шүлэгч байв. Петөфи зөвхөн феодалын дарлалын эсрэг тэмцэгч биш бүх төрлийн дарлалыг үзэн яддаг байлаа. Петөфи зөвхөн унгар түмний дарлалын эсрэг боссон бус, бүх дэлхийн улс үндэсний дарлалын эсрэг боссон хүн. Петөфи тэр үеийн Унгарын байдлыг дүрсэлж бичихдээ:

Хувьтай нэг нь жаргасаар л байна
Ходоодоо хагартал чихсээр л байна
Харин эх орны ядуу үрс
Харангалан өлбөрч үхсээр л байна... гэжээ.

Петөфи Унгарт заавал хувьсгал үүснэ гэдгийг зөгнөн мөрөөдөж байсан. Шүлэгч, хувьсгалт тэмцэлд ядуу ард түмэн дийлнэ гэдэгт бат итгэж,

Эрх чөлөөний дайсан цусандаа живнэ
Энэ хорвоо зовлонгоос ангижирна... гэж бичиж байв.

Петөфи хувьсгалд яг тулж орохоосоо өмнөхөн Юлия Сенурей хэмээх бүсгүйтэй гэрлэжээ. Энэ хоёрын хайр дурлал бол нэг зүг тэмүүлсэн хоёр хүний оюун санааны нэгдэл байв. Хэрэв тиймгүй байсан бол баян язгууртны танхил охин тэнүүлч шүлэгчтэй хаанаас суух вэ дээ! Юлия Сенурей дэвшилт үзэл санаа бүхий эмэгтэй байв. Тэрээр Францын нэрт зохиолч Жорж Сандын зохиолыг шуналтайгаар уншиж, эмэгтэй хүний эрх чөлөөний төлөө сэтгэл түгшин бодолхийлж байжээ. Петөфи хамгийн шилдэг хайрын шүлгүүдээ Юлияд зориулсан юмаа. Эдгээр шүлгийн ихэнхэд нь хайр дурлал, эрх чөлөө хоёрыг хослон дуулсан байдаг. “Янаг амраг, эрх чөлөө” гэдэг шүлэгтээ:

Янаг амраг, эрх чөлөө
Яасан ч энэ хоёр хэрэгтэй.
Амрагтай болохын төлөө
Амь алдсан ч над хамаагүй.
Эрх чөлөөний төлөө л

Энхрий янагаа ч хайрлахгүй... гэж бичсэн байна. 1848 оны нэгдүгээр сард Италид хувьсгал гарсан мэдээ сонсоод Петөфи эхнэрийгээ “Туг оё” гэж уриалж байв. Юлия үнэхээр эрх чөлөөний туг оёсон. Унгарын хувьсгалын өдрүүдэд Юлиагийн уран гараар оёсон туг Пештийн хувьсгалт залуучуудын туг болсон билээ. Хаа ч болов хайрт амрагтайгаа хамт явахыг мөрөөдөж “тулалдааны талбарт олсон шархыг чи минь үнсээд эм шиг эдгээнэ, гарсан цусыг минь нулимсаараа угаагаад рашаан шиг цэвэрлэнэ” гэж Петөфи бичиж байсан билээ. 1848 оны гуравдугаар сард Унгарын хөрөнгөтний хувьсгал эхлэв. Энэ хувьсгалд Петөфи хамгийн идэвхтэй оролцсон. Петөфи хувьсгалыг зөвхөн хөрөнгөтний

ардчилсан хувьсгалаар хязгаарлахыг огтхон ч бодоогүй. Тэрээр “Хувьсгал бол иргэний дайн мөн. Унгарын хувьсгалчид, Унгарын хувьсгалын эсэргүүчүүдтэй тулалдах хэрэгтэй” гэж уриалж байв. Петөфи хувьсгалт цэрэгт ороод, эхлээд ахмад, дараа нь хошууч болсон. Ингэж явахдаа хувьсгалт цэргийн ялалт, баатарлаг гавьяаг магтан дуулж, тэднийг тэмцэлд зоригжуулж байв. Петөфи хаант Оросын түрэмгий цэргийн эсрэг 1849 оны долдугаар сарын 31-нд дайны талбарт нас барсан билээ. Петөфи бол дэлхий дахины эрх чөлөөний шүлэгч, Петөфи бол Унгарын утга зохиолын бүхэл бүтэн үе мөн. Унгарын ардач уран зохиолын эхлэлт, цэцэглэлт нь Петөфийн уран бүтээлтэй нягт холбоотой. Хувьсгалч шүлэгч, Петөфийн ардач яруу найраг бол Унгарын үндэсний яруу найргийн охь манлай мөн. Петөфи бол ард түмний дундаас төрж гараад ард түмний төлөө амь насаа зориулсан шүлэгч байв. Петөфийн ойлгож байснаар ардач утга зохиол гэдэг бол ардын аман зохиолыг хэлбэрийг ашиглаж ард түмний санаа бодлыг илэрхийлсэн байх хэрэгтэй юм аа. Петөфи бол сайн сайхан юмыг магтан дуулж, муу муухай юмыг жигшин үздэг байв. Петөфи энэ ертөнцөд сайн ч юм их бий, муу ч юм их бий, сайн нь хэзээ нэгэн цагт дийлнэ гэж юмыг үргэлж сайн талаар боддог хүн байжээ. Тэр цагийн бурангуй Унгар нийгмийн дотроос Петөфийн шүлэг л цагийн шалгалт давж, эдүгээ хүртэл даян дэлхийд түгэн тарсаар байгаа нь энэ буюу.

Г.Очирбат





Б.Ринчиний орчуулга

АМЬД ЯВАХ, ҮХЭХ ХОЁР

Богинохон энэ л насандаа
Бор дарс уун, богтотыг тэвэрч,
Эх орныхоо төлөө амиа өгөх хүн
Эгнэгт их буянтан хүн биш үү?

Тайлбар: Монгол хэлэнд богтот гэж богтолсон хүн, эмэгтэй хүн гэсэн үг. Урьд цагт богт гэж богтолсон эмэгтэй хүний өмсдөг малгайг бас нэрлэдэг байжээ.



Б.Ринчиний орчуулга

ЭХ ОРНЫ ТӨЛӨӨ СОГТОНО

За, оочоод бай, та минь ээ!
Залгиад байна даа би чинь,
Хөлчүү согтуу байхдаа
Хөөрхий улс минь
Согтуу нүдэнд соньхон сайхан!
Хөлчүү миний нүдэнд эх орон
Хөгжилтэй сайхан ч юм шиг
Балгаад орхиход баалж байсан
Бас нэг шарх нь битүүрэх шиг
Өр өвдөх минь гайгүй болдог шүү!
Хөөрхий эх оронд маань
Хөлчүү минь тус болдогсон бол
Үхэлгүй мөнх наслах сан,
Өдөр шөнийг ялгалгүй
Ингээд л оочоод байхсан би!



Б.Ринчиний орчуулга.

АЖИЛЧ ЯАНОШ

Ажилдаа ч галзуу даа
Авдранд нь мөнгөгүй
Гар хоосон байдаг
Гайтай нэг зовлонтой.

Тарьсан тариа будаа нь
Таатай ургадгийг хэлэх үү,
Тариагаа худалдаад
Гар хоосон байдгийг хэлэх үү?

Архины пүүзэнд ороод
Амсах юм байна уу? Гэдэггүй
Яагаад сархад зооглодоггүй
Яанош түүнд мөнгө байдаггүй вэ?

Ажилчин залуу хар хүүтэй
Авгай нь даанч сайн байхад
Яаношийн олсон мөнгө нь
Яаж ч тэсэх вэ дээ?



Б.Ринчиний орчуулга

ИНТООРЫН ЖИМС, МӨЧРӨӨС НЬ САЙН ЧИМХДЭГ БАЙЛАА

Интоорын жимс, мөчрөөс нь
Та минь ээ!
Сайн чимхдэг байлаа
Нэг эхнэр аваад л гэртээ
Ёслол авчирсан чинь
Та минь ээ!
Хөөрхий намайг ханан гэрээс
Хадан гэрт гаргачихад дөхсөн шүү!
Догшин ч зантай заяаж дээ,
Та минь ээ!
Тэнгэр бурхан түүний минь
Харахаасаа л өвдөг минь чичрээд
Хэцүү дээ, манай авгайн ааш зан
Аль! Гэхэд нь байдгаа өгчихөөд
Ёох, та минь ээ
Өөдөөсөө хуцуулдгийг минь яана!
Зодоод залхаах юмсан энэ мууг,
Та минь ээ!
Энэ чавганц хүч буурай шүү
Та минь ээ!
Эр намайг яаж дийлэх вэ гэтэл
Ууртай нүдээрээ намайг ширвэхэд нь
Уушиг зүрх минь амаараа гарах гэдэг шүү
Та минь ээ!
Үхэж тамд орох болж тэр минь
Та минь ээ!

Одоо л нэг санаа амарлаа гэж
Тэсгэлгүй баярласныг хэлэх үү?
Тийм эмийг эрлэгч аваачдаггүй
Эрлэг тамын газар хавьтуулдаггүй
Эргүүлэн буцаадгий нь хэлэх үү
Та минь ээ!



Б.Ринчиний орчуулга

ЗАЛЬТАЙ АРХИЧ

Архинд дуртай би, гэсэн ч заримдаа
Аманд ороод цаашаа явдаггүй нь сонин шүү.
Зальтай архи ч заавал аргалах ёстой доо.
Шалчийтал согтоход шалтаг байх ёстой доо.
Энэ цом чинь, хааны зүрх гэж бодъё доо,
Эзэрхэг түүний цусыг нь соръё доо гэхэд
Сороод байтал, цомоо шавхчихдаг шүү!



Б.Ринчиний орчуулга

ЯАГААД

Бузар булайчууд бүгдийг
Бултаар нь дүүжилбэл яадаг бол?
Эс болдог учрыг нь бодвол
Энэ дэлхийн мод гүйцэхгүй
Нэг тийм учир байдаг болов уу?
Бузар булайчуудыг олныг хэлбэл
Бултаараа нэг нэг дусал болоод
Дусал дуслар бороо шиг орвол,
Дөчин хоног зүс бороо орж,
Усан галав юүлэхсэн байх!



Б.Ринчиний орчуулга

ААВЫН САНААГААР БОЛ

Аавын санаагаар бол намайгаа
Ажлыг нь залгамжлаасай гэж,
Яргачин болгох санаатай билээ.
Яруу найрагч болчихож, би нь.

Үхрийг сүхээрээ аав духаддаг.
Үзгээрээ хүнийг, би духаддаг.
Нэг л ажил юм биш үү дээ.
Нэр нь л ондоо болохоос биш.



Б.Ринчиний орчуулга

МИНИЙ МУУ ШҮЛГИЙН УЧИР

Аятай сайхан юм
Амралтгүй бичиж болно.
Хааяа хааяа би чинь
Хамаагүй бичдэг шүү.
Дан сайхан юм л
Дандаа бичээд байвал
Хөөрхий шүүмжлэгч тэдэнд
Хөсөрдөх цаг ирэх бий.
Хогийн муу юм л тэдэнд
Хоол нь болдог юм биш үү дээ?
Хоолойг нь зангируулаад
Хоолноос нь салгаад ямай
Амьтан юм биш үү дээ тэдэн,
Амандаа гараа чихэг дээ,
Гэдийглээ ханаг дээ тэдэн
Гэдэс гаран цадаг дээ!



Б.Ринчиний орчуулга

КАВОШ ЯАНОШИЙН АВГАЙН АЛЬБОМД

За! Үзэлгүй гэдэг чинь энэ эрин цагийн гай!
Үзэл гэдгийн ганц хүчинд л ерөөсөө
Хүн гэдэг маань, хүн болж байгаа юм шүү
Үзэлгүй биш бол адгууснаас дээр нь юу вэ?
Хүн төрөлхтний өмнөөс, эх орны өмнөөс
Авгай чамайг би давхар гуйя, хичээ
Тэнгэр чамд хүүхэд заяадаг юм бол
Тэднээ чин бат ариун үзэлтэй болгож
Хүмүүжүүлж сургаж үзээрэй, чи минь,
Үзэлтэй л болоод ирвэл, үр хүүхдэд чинь
Бусад зүйлийн эрдэм аяндаа бүрдээд ирнэ!



Б.Ринчиний орчуулга

ЦАГ ОНDOO БОЛЖЭЭ, ХОРВООД

Цаг ондоо болжээ, хорвоод!
Урьдын цагт болбол,
Эрдэмтэн хүн илжиг унадаг сан.
Одоо харин үзвэл
Илжиг нь унаатай болоод
Эрдэмтэн нь явган гэлдэрдэг болжээ.



Б.Ринчиний орчуулга

ХҮНИЙ АМЬ ГЭДЭГ ЧИНЬ...

Хүний амь нас гэдэг чинь...
Хөгшин гуранч ёроолыг нь долоодог
Сэтэрхий муу аяганы дайгүй ч юм шив дээ.



Б.Ринчиний орчуулга

АРД ТҮМЭН

Өрөөсөн гараараа анжис бариад,
Өрөөсөн гартаа илдээ атгаад,
Ард түмэн, хөөрхий түмэн минь!
Цусаа ч гоожуулж, хөлсөө ч гоожуулж
Насараа л ингэж зовж явдаг даа,
Зовсны нь хариуд юу олдов? Гэвэл
Амандаа идэх, мөрөндөө тохох төдийхөн
Өчүүхэн түүний нь тэгж зоволтгүй
Өргөн дэлхий нийлүүлж болохгүй яах вэ?
Ард түмэн дайсантай сүрхий тулалддаг
Юухны төлөө тулалдан байлддаг вэ?
Эх орны төлөө юү? Чааваас даа!
Эрх мэдэлтэй газар эх орон байдаг юм.
Эрх нь хаа байна, ард түмэн минь?



Б.Ринчиний орчуулга

ЯНАГ АМРАГ, ЭРХ ЧӨЛӨӨ

Янаг амраг, эрх чөлөө
Яасан ч энэ хоёр хэрэгтэй!
Амрагтай болохын төлөө
Амь алдсан ч над хамаагүй
Эрх чөлөөний төлөө л
Энхрий янагаа ч хайрлахгүй!



Б.Ринчиний орчуулга

НАЖКААРОЙД

1846 оны 9-р сарын 7-нд
Эрхэм их үг хэлсэндээ
Энд чи минь, Көлчей минь
Айхгүй юм уу даа амьтан,
Ариун энэ газрыг бузарлаж,
Аягүй муухай юм хийхдээ?
Сүртэй сүнс нь авснаасаа
Босоод ирвэл яана, таануус?
Хэл амаа тат гээд багалзуураас
Хувхай ясан гараараа базаж
Тас атгавал яана, таануус?

Үгүй, булшнаасаа тэр хүн босохгүй
Тануус юу ч гэж хэлэлцэцгээсэн
Булшин дотроо гашуунаар уйлж,
Булай муухайн бузарт унаган
Улс түмнээ харамсаж байгаа даа!
Яасан зусар бялдууч вэ, тануус!
Аялдан дагалдвал дэвшинэ гэж
Өдөр ирэх тусам бууж өгдөг,
Ер нь нохой шиг шарваач тануус
Нохойн жороогоор жороолох юм биш үү?
Хүний оронцог болсон эднүүсд
Хүзүүнд нь дөнгө зүүлгэж тагнаад
Заяа тэнгэр, гав гинж зүүж,
Зад ташуурдан махыг нь иддэг
Занчаа харгисыг заяаж залхаагаасай.



Б.Ринчиний орчуулга

ЭР ХҮН БОЛ, ЭР ХҮН ШИГ БАЙ...

Эр хүн бол, эр хүн шиг бай,
Үлээхэд цаашаа,
Өрөвхийхэд наашаа
Тийм тоглоом бүү бол,
Нохойн бурахад
Ноцохоос нь бүү ай,
Эр зориг гаргаж
Эрслэн алхаад бай!

Эр хүн бол, эр хүн шиг бай!
Хоосон олон үг дэмий,
Хотол олонд тустай
Бүтээлт үйлс, эрийн чимэг
Чин зориг барьж
Чинээгээрээ зүтгэж,
Санаснаа бүтээгээд
Сагсууран бүү хөөр!

Эр хүн бол, эр хүн шиг бай!
Зөв гэж бодвол, зүрхтэй бай,
Үнэний төлөө үхэхээс бүү ай
Журам алдаж, нэр хугарснаас
Зуу дахин үхсэн дээр бий!
Царай алдаж биеэ бузарлаад,
Амьд явсны хэрэг чамд
Ашигтай гэж бодвол дэмий.



Эр хүн бол, эр хүн шиг бай!
Энэ ертөнцийн жаргалаас
Эрх чөлөөгөө өгвөл
Эр хүн биш эрэнцэр
Жаргалын төлөө биеэ худалдвал
Шившгийн муу тэр ээ.
Гүйж явсан ч яамай,
Эрх чөлөөгөө л бүү алд!

Эр хүн бол, эр хүн шиг бай!
Тэмцэлд зоригтой бол,
Тэнгэр, хүмүүс хэн ч
Дарж чадахгүй, чамайг
Догшин салхинд дайруулавч
Хуга татуулахаас
Хулчийж бөхийдөггүй
Хатан царс мод шиг бай!



Б.Ринчиний орчуулга

ШҮҮГЧ НАР, ШҮҮГЧ НАР.,

Шүүгч нар, шүүгч нар хянуур бай
Шүүхийн тогтоол тоглоом биш шүү!
Цаазаар аваачна гэхдээ, та минь
Цалгардалгүй нарийн шалгаж бай!
Дуугаа намд, шүүгчээ шийдвэрээ хэлж
Дуугүй цаазал! гэж сүртэйгээр хэлээд
Залуу эрийг толгойн цаазаар авах гэж
Зандалчин сүхээ бариад хүрч ирлээ.
Өглөөний улаан нар мандахын үед
Өнөө залуугийн толгой ойчоод,
Годхийж улаан цус олгойдон
Гоё сайхан цусан оргилуур аа.
Шөнө дунд, сарны гэрэл юутай хачин...
Шийтгүүлсэн тэр залуу эр гэнэтхэн
Чийгтэй булшны нүхнээс гараад,
Чигээрээ босоод ирж гэнэ шүү.
Цус болсон толгойгоо үснээс нь
Цувдай шиг атгаад явж гэнэ шүү.
Олон гудам хаалга дамжсаар
Онц л тэр шүүгчийн хаалганд хүрч,
Түмэн хилээр амиа алдсан гэхэд нь
Түжигнэтэл шүүгч нь чичрээд сэртэл
Түсхийж хаалга нь гэнэт нээгдээд,
Түрчиг тарчиг толгой өнхрөн орлоо!
Тэрнээс хойш шөнө бүр салахгүй,
Тэр залуу эр, хаалгын өмнө зогсон
Хилээр хүн алдаг шүүгчдийг шүүмжлэн
Хилэгнэн толгойгоороо чулууддаг гэнэ.



С.Доржпаламын орчуулга

ГАНЦХАН ЭВГҮЙ БОДОЛ СЭТГЭЛИЙГ МИНЬ ТҮГШЭЭХ ЮМ

Гадна дотно хоёроосоо өтөнд нэвт идүүлж
Гандан хатсаар төгсөх цэцгийн шаналгаат үхэл шиг
Гарцаагүй би хучлага дотроо үхэх бий гэхээс,
Ганцхан эвгүй бодол сэтгэлийг минь түгшээх юм,
Хоосон тасалгаанд мартагдсан зул бөхөхийн адил,
Хожмын нэг өдөр би удаан зовж үхэх вий!
Үгүй! Тийм үхлийг хэрхэвч би хүсэхгүй!
Үүнээс өөрөөр үхэхийг би хүсэж байна.
Аянганд ниргүүлж, царс мод салам цохиулах адил
Аюулт шуурганд нарс үндэстэйгээ булгарч унахын адил
Газар тэнгэр доргиулсан хүчит цууриа хадуулсаар
Хавцлын хад нурах шиг тийм үхлийг би хүснэ.
Ард түмэн гашуун зовлонгийн дөнгөө авч хаяад
Ариун эрх чөлөөний улаан тугаа гартаа бариад
Зол жаргалын төлөө үзэлцэн тэмцэхээр босч
Зориг зүрх нь бадарч тулалдаанд орох цагт
Зүүнээс баруун тийш тэмцлийн уриагаа түгээж,
Зандалчин харгисуудыг чичрээн сүрдүүлэх үед
Хамаагүй би тэр цагт л газар хөсөрдөн ойчиг!
Халуун амьсгалаа хураах шалтгаан тэгэхэд олог!
Халуун цус минь цээжнээс оргилон урсаж байхад
Зангирч догдолсон сэтгэлээс баярын үгээ хэлнэ!

Эргэн тойрон нижигнэсэн бүрээ, буу хоёрын дуу
Эрсэлж хэлсэн үгийг минь дуулдамгүй дараг!
Гэрэлт ялалтын зүг хурдалж яваа морин цэрэг
Хэвтэж байгаа миний дээгүүр харайлган гараг!
Гэсэн ч тэдний морины хамар тачигнахыг би сонсоно.
Ойчсон газраа яс минь огт хөдлөлгүй хэвтэж л байг!
Олон нөхдийг минь оршуулах их гашуудал болоход
Алтан дэлхийн эрх чөлөө олгох гэж тэмцсээр
Ариун сайхан амь насаа алдсан зоригтноо
Ах дүүс бүх баатрын нэг булшинд оршуулж
Аялгуут хөгжим уянгалуулж, тугаа бөхийлгөн
гашуудацгаа!



С.Доржпаламын орчуулга

ГЭГЭЭН ДАЙНЫГ БИ ХҮСЭЖ БАЙНА

Хуучин ертөнцийг хэмхчин нурааж
Хувхайрч эвдэрсэн орон дээр нь
Гэрэлт шинэ ертөнцийг байгуулах
Гэгээн дайныг би хүсэж байна.

Тэнгэрийн дууны хүчийг нэмсээр
Тэмцлийн бүрээ хангинаж дуугараасай.
Тэр тулалдааны догшин уриаг
Тэсэж ядан би хүлээж байна.

Эмээлийг нь ч хайхралгүй мориндоо мордож
Эр цэргийн эгнээнд зэрэгцэж
Эрчилж довтолгон тулалдаанд орохоор
Энгүй баяртай нисэн одно.

Хорт сум цээжийг нь цөмлөвөл
Хамаг шархыг минь арилган боож
Хайрын үнсэлтээр адислан эдгээх
Халуун сэтгэлтэн над олдоно.

Харийн дайсны гарт олзлогдвол
Харанхуй гянданд минь хүрэлцэн ирж
Үүрийн цолмон шиг хайрын гэрлээр
Үнэнч амраг минь намайг гийгүүлнэ.

Алуурын газар толгойгоо цавчуулсан ч
Аймшигт догшин тулалдаанд үхсэн ч
Нэвт дохиулсан цээжний минь цусыг тэр
Гэрэлт нулимсаар угаан цэвэрлэнэ.



С.Доржпаламын орчуулга

ЧОНЫН ДУУ

Бургаж бүрхсэн алсад
Өвлийн шуурга исгэрнэ.
Бороо цас холилдож
Нүд чихгүй шуурна.
Бүгж түр амсхийх
Бөргийх бут ч олдохгүй.
Буйд зэлүүд цөл дунд
Бүх насаараа тэнэнэ.
Тасхийм жаварт хайрагдаж
Тэсэхийн аргагүй өлсөнө.
Ийм хоёр зовлон
Энэрэл хайргүй тарчилгана.
Буутай хүн ирвэл
Буман зовлон нэмэгдэнэ.
Уудам талын цасыг
Улаан цусаараа будна.
Бөөрөө нэвт буудуулсан ч
Бүхэл өдөржин зовсон ч
Харангадаж хөлдөж явсан ч
Хаа ч бид чөлөөтэй юм шүү.



С.Доржпаламын орчуулга

ХАЙРТАЙ БИ

Хонгор чамдаа хайртай
Хосгүй их хайртай
Гунхсан зэгзгэр биенд чинь
Гуа сайхан гэзгэнд чинь,
Цэвэр тунгалаг нүдэнд чинь
Цээл уяхан хоолойд чинь
Эрүүл ягаан хацарт чинь
Энгүй зөөлөн гарт чинь
Элэг зүрхнээсээ хайртай.
Зөөлөн гарын чинь хурууг
Зүрх догдлон атгахаар
Сэмхэн дөнгөж шүргэхэд
Сэтгэл бахтай болдог.
Өгөөмөр хүслийн уужим нь
Өргөн талын зайтай
Өрнөх баян сэтгэл чинь
Өндөр уулын дайтай.
Уйтгар гунигт дарагдаад
Уйлж хайлах нь сонин,
Хөгжилд баяртай болоод
Хөхөрч инээх нь сайхан,
Сайхан гэгч инээмсэглэхэд чинь
Сар гэрэлтэх шиг болдог
Над гомдож уурлахад чинь
Нар хиртэх шиг санагддаг.
Хонгор чамдаа хайртай.
Хосгүй их хайртай.
Ариун нандин сэтгэлээр

Амраг чамдаа хайртай.
Хонгор чиний эзгүйд
Хурмаст тэнгэр хүртэл
Хувхай юм шиг санагдана.
Зүрхний амраг чамайгаа
Зүүдэн дундаа дуудна.
Амь сүнс хоёр минь
Амраг чамтай л холбоотой.
Ямар ч өндөр алдрыг
Янаг чамдаа олно.
Алдар нэрэнд хэрэв
Амраг чи минь дургүй бол
Амьдарч чамтай байхын тул
Аль ч алдраас зугатна.
Чадал хүчээ гаргаж
Чамдаа хэрвээ тусалбал
Ямар ч хохирол хүлээсэн
Ямагт баяртай явна.
Өчүүхэн төдий унтууцах
Өө шалтаг гарчихад
Үртсийн чинээ юм ч
Өсөж том болчихоод,
Үнэнч чамайгаа гомдоовол
Үргэлж надад зовиуртай.
Хөрст алтан дэлхийд
Хэзээ ч хэнд ч байгаагүй.
Хүчит их сэтгэлээр
Үүрд чамайгаа хайрлажээ.
Үнэнч амраг чамдаа
Үхлээ би хайртай шүү.





Энхрий сайхан биенд нь
Элэгтэн бүхнээ нэгтгэж
Эр хонгор нөхрөө гэж
Ижил сайхан ханиа гэж
Энэрэл ихтэй эцгээ гэж
Энхрийлэн таалж хайрлах нь
Энэ хорвоод үгүй буй заа
Гэтэл харин би чинь
Гэнэн хөөрхөн охиноо,
Гэмгүй сайн эгчээ,
Гэрэлт сайхан ханиа гэж
Ганцхан чамдаа нэгтгэж
Гарцаагүй бодож явдаг.
Чин үнэн зүрхнээс
Цэвэр тунгалаг сэтгэлээс
Уужим гэрэлт бодлоос
Ухаангүй их дурлажээ.
Янаг амрагийн хайранд
Шагнал хэрвээ байдаг бол
Яалаа ч би горьдохгүй,
Цөмийг нь чи хүртэх вий.
Сайхан бүхнийг бэлэглэж
Гайхуулж чамайг магтах нь
Нандин янаг хайранд
Намайг сургасны шан шүү.



Д.Гомбожавын орчуулга

МАРТАЖ ЧАДАХГҮЙ НЬ

Өнөд чамайг мартахыг
Өнөө хүртэл хичээвч
Чин сэтгэлийг угаас
Чи салдаггүй нь юу вэ?

Хар үсээ намилзуулж
Хар нүдээ тормолзуулж
Хараагүй байхад харагддаг
Хачин янзын бүсгүй вэ?

Солонгын туяа татсан
Содхон замын адил
Оюун санаа хөдөлж
Онц догдлох нь юу вэ?

Холдон одох аргагүй
Хойшоо хоргодох нь юу вэ?
Тамын энэ гинж
Тасарч орхидоггүй нь юу вэ?

Анхил чиний дүр
Ашид над үзэгдэж
Хонгор ариун царай чинь
Холдож өгдөггүй нь юу вэ?





Сэтгэл зүрхэнд минь амрахаар
Шувуу шиг нисээд ирэвч
Эгшин зуур тогтолгүй
Эргэн одох нь юу вэ?

Гамшиг таригч од
Гайгаар чамайг хөтөлж
Хөх далайн дунд
Хөлгийг залан одном.

Тэр одны хойноос
Тэртээд онгоц арилж
Ууртай догшин долгионд
Ул мөргүй замхарнам.

Ирэх шөнийн зүүд шиг
Ингээд арилах юм бол
Нандин хайрт чи минь
Надтай учрах нь нь юу вэ?

Эргэж чамтай золгохыг
Эрсхэн сэтгэл найдаад
Баярлан учрах мөчид
Бас л би итгэвч

Чимээгүй шөнийн гүнд ч
Чиний халуун тэврэлтийг
Хоосон горьдох сэтгэлдээ
Хоромхон ч би үзэхгүй нь.

Амаргүй бодолд автаж
Арайхийж нэг салаад
Гэнэн хонгорын жигүүр ургуулж
Эрээн цоохор эрвээхэй шиг
Илчит наранд биеэ даатгав.

Чамайг мөрөөдөх сэтгэл
Намайг гэвч орхилгүй
Богино жигүүрийг тасдан
Бүр алсад хийсгэв.

Урьдын амссан гуниг
Урхидан бас дөнгөлөөд
Оргон зайлахыг бодовч
Осолдон баригдсан ялтан шиг
Ёроолгүй тамын харанхуйд
Ёроор дахин оров.

Зүрх сэтгэлийг дөнгөлсөн
Зүйргүй хэцүү гинжээс
Аврах хүн бий юу?
Ачаа одоо хүргээч.

Нээрээ чи минь намайгаа
Нэг ч юмгүй мартлаа гэж үү?
Урьдын адил хайртай гэж
Учиртай үгээ хэлээч!



Амраг хайртай чи минь
Аминчилж намайг бодооч
Хорт гинжийг тасалж,
Хонгор зүрхийг авраач!

Шударга журам сахин
Шууд л сэтгэлтэй болчихвол
Орчлонгийн бусад юмыг
Ор мартах учиртай.

Чиний хорвоо би юм.
Миний бурхан чи юм.
Өөр зүйл бидэнд
Өчүүхэн төдий ч хэрэггүй.

Тэмүүлэх ариун сэтгэл
Тэнгэрийн шуурга шиг оргилж
Тэр их шуургатай
Тэнцэх хүчин дутагдвал,

Үнэхээр над чи минь
Үүрд үнэнч байвал
Салж хагацахын зовлон ч
Саад тотгор болохгүй
Хагацал үзсэн бид хоёрыг
Хараад атаархах хүн бий.



Д.Гомбожавын орчуулга

НАМАЙГ ХҮН БОЛГОН НАЙРАГЧ ГЭЖ ЯРИХ ЮМ

Намайг хүн болгон
Найрагч гэж ярих юм.
Би ч гэсэн өөрөө
Бас л тэгж бодох юм.
Танхил хайрт чи
Таашааж намайг бүү магт.
Хайрт чамтай зүйрлэвэл би
Хаана ч хүрэхгүй шүү дээ.
Бодож санасан бүхэн чинь
Бүлээхэн зөөлөн амьсгаа чинь
Инээвхийлэх учиртай уруул чинь
Эрэвгэр хоёр нүд чинь
Хангинасан уяхан дуу чинь
Хайрын уяхан инээд чинь
Таван зуун шүлгээс ч
Тансаг яруу найраг юм шүү!





Д.Гомбожавын орчуулга

САНАЖ БАЙНА УУ?

Энэ цөөрмийг хоёулаа
Эхэлж харснаа санана уу?
Саяхан л мэт бодогдовч
Санаандгүй хоёр жил болжээ.
Цэнхэрхэн тэнгэр өөд
Цээлхэн мөчир сэрийлгээд
Модны алтан навчис шарласан
Мөн л иймэрхүү намар байсан.
Тунгалаг хөх тэнгэрийг
Тусгаж цөөрөм тольдоод
Уяатай бяцхан завь
Урсгал дагуу дайвж байсан.
Сайн сайхан жаргалыг
Санаандаа л ганц зөгнөөд
Үнэнийг хэлэхэд чамайг
Үнсэхийг зүрхэлдэггүй байсан.
Хайран хоёр жил өнгөрөв гэж
Харамсах явдал алга.
Энэ хооронд л чухам
Их буян хүртэв.
Энэ хорвоо ертөнц
Энэрч намайг аварсангүй.
Оронд нь чамайг заяасан болохоор
Огтхон ч би гомдохгүй.
Амраг чамайг бодохоос ч
Айж байсан энэ газар
Хоёул жаахан байя.
Хосгүй цэнгэн наадъя.



Д.Гомбожавын орчуулга

САЛЖ МОРДОХДОО ХЭЛСЭН ҮГ

Үүр сая л цайсансан
Үдэш нэгэнт болчихжээ.
Осолгүй буцах тулчихжээ.
Арайхийн чамайг үнссэнсэн.
Ахиад хагацах болчихжээ.
Салах ёс хийж
Санаа үгээ дэлгэжээ.
Амин сүнс минь, хонгор минь!
Ачит бурхан өршөөг!
Бийрээ гэртээ орхиод
Сэлмээ гартаа атгалаа.
Эгшигт шүлэгчээ болиод
Эр цэрэг боллоо.
Алсын замыг минь одоо
Алтан гадас заахгүй.
Урьдах зам минь тэгээд
Улаан өнгөөр туяарна.
Амин сүнс минь, хонгор минь!
Ачит бурхан өршөөг!
Аялах замд орохдоо
Онцгой гавьяа эрээгүй.
Алдар нэрийн титэм
Аз жаргалын цэцэг
Байгаа ганц биенд
Багтаж хоёул чадахгүй.
Амин сүнс минь хонгор минь!
Ачит бурхан өршөөг!
Аялах замд орохдоо



Алдар нэрийг горьдоогүй.
Аминч тийм үзэл
Аль хэдийн өнгөрсөн.
Улс орныхоо төлөө
Улаан цусаа урсгана.
Дайсныг хөнөөхийн төлөө
Дайнд би мордлоо.
Амин сүнс минь, хонгор минь!
Ачит бурхан өршөөг!
Эх орныхоо төлөө
Эхнэр чиний төлөө
Эрслэн тулах үед
Эгнэгт намайг дурсаарай гэж
Хайрт янаг чамдаа
Хандаж би захихгүй.
Үнэнч ганц намайгаа
Үүрд чи мартахгүй.
Амин сүнс минь, хонгор минь!
Ачит бурхан өршөөг!
Эрэмдэг зэрэмдэг болчихоод
Эргэж очиж мэднэ.
Тэглээ ч гэсэн чи минь
Тэвэрч намайгаа энхрийлнэ.
Буцашгүй бат сэтгэлийг чинь
Бууршгүй ганц зүрхийг чинь
Эрхт тэнгэр өөрөө
Эндэхгүй сайн мэднэ.
Амин сүнс минь хонгор минь!
Ачит бурхан өршөөг!



Д.Гомбожавын орчуулга

ШАЛГО

Хилэгнэсэн арслан дэлээ хийсгэж
Хэтийг ширтэн өлийн зогсох мэт
Ноградаас Гемёр хүртэл цувсан
Нүүгэлтсэн хар уул дүнсийн барайна.
Тэнгэрийн муухайд өндөр уул дээр
Тэмээн жингийн цуваа шиг үүл
Хуран тогтоод бүрэлзэн харагдана.
Холын замдаа амран саатна.
Борооны ширүүн усны үеэр
Булай догшин эзэндээ зориулж
Хурмастын дархан аянга авгай
Хуйлрах цахилгаан сумаа хөвчилнө.
Энэ газар Шалго хэмээх
Эртний цуутай шилтгээн байжээ.
Гараараа хурмаст өөд сарвайж
Гараг мичдэд санаархан байжээ.
Тэргүүнээрээ тэнгэр тэвхдээд
Тамын хар нүх дотроо ухжээ.
Түмэн үеийн хөлд дарагдаж
Тэгш хана хэрэм нь нуржээ.
Зугаа цэнгэлд сэтгэл нь ханаад
Зугтаж яваа далавч шиг
Энд тэнд эвдэрхий балгас
Энэлж шаналж цагийг нөгцөөнө.
Налайсан зуны ид дундуур
Намайсан тогтуун нэг өдөр
Эвдэрхий хэрэмний дэргэд ирээд
Элдвийг би бодож билээ.





Торноос салсан шувуухайн адил
Торох саадгүй миний харц
Мянган бээрийн хөхрөх, уудмыг
Мягаршгүй нүдээр ширтэж билээ.
Урсан одох гол горхи
Умдаалан идээшлэх мал сүрэг
Тэртээ тосгоны хонхт цамхаг
Тэнүүн нарны туяанд ярайна.
Гэвч би өөр юм бодож
Гиюүрсэн сэтгэл холдон арилж
Өнө дээрийн түүх домгийн
Өөдөс хэлтэрхийг сэргээж ирэв.
Дундад эриний аймшигт хорвоо
Дайн самууны гамшигт улбаа
Зэрэглээ адил миний өмнө
Зэвхий даагаад бүрэлзэж ирэв.
Эзэн Эндре хальж одоод
Эртний алдрын нар жаргаад
Эг маггүй харанхуй шөнө
Эх нутгийг минь бүрхэн авсан
Арван дөрөвдүгээр зуун
Аяндаа миний санаад орлоо.
Өш хонзонгийн тэмцэл дэгдэж
Өөдгүй бүхэн толгойгоо өндийлгөв.
Муу эр дүүвэйнд, чоно бороонд гэгчээр
Мулгуу нэг нь эх орноо ч хайхрахаа болив.
Ариун тангарагаа умартсан хөвүүд
Ачит эх шиг Унгар нутгаа
Хүний цусанд живүүлж билээ.
Хүйтэн элэгтэн улангасаж билээ.
Эрхэмсэг шилтгээн, орд харш
Эзэрхэг дээрэмчний үүр болж

Эрээ цээргүй найрлах болжээ.
Хөдөө хөндийд айн бэмбэгнэх
Хөдөөх хүмүүсийг элэг барих нь
Намрын бороо туяхан шавшихыг
Өвлийн шуурга инээн шоолох мэт
Нэрийг нь хэлэхдээ чичрэн айдаг
Нэг нэгэндээ аяар шивнэдэг
Эзэн ноён Петр Комполин
Энэ шилтгээнд суудаг байжээ.
Шалго нэртэй шилтгээн тэгээд
Шалиг дээрмийн орон болжээ.
Эвлэрсэн нэгийг нь өөртөө нийлүүлж
Эсэргүүцсэн нэгийг нь өшин тамлаж
Орон гэрийг нь шатаан талж
Олонд алдаршсан ноён байжээ.
Балай үйлст эцэг ноёныхоо
Баруун гар нь болсон хөвүүд
Иов, Даанд хоёр нь
Эцгээсээ дутуугүй яргачин ажээ.
Халдаж тэдний цөмрөөгүй
Харгисалж тэдний цөлмөөгүй
Орон нутаг, эзэмшил газар
Ойр хавьд нь олдохоо больжээ.
Тулаанд элсэн баавгайн арьсан дээр
Тухлан суугаад архи залгилж
Хаашаа дайрах, хэнийг эзлэхээ
Харилцан тэд хүүрнэн зөвлөнө.
Архи дарсанд судас нь гүрийж
Аймшигт царай нь сүртэй барайж
Эцэг ноён нь хундагаа өргөөд
“Энэ хундагыг Гедэд зориулъя
Эрхэм түүнийг маргааш дайръя





Эрхт тэнгэр өршөөг” гэв.
“Гедийн төлөө ууцгааяа” гэж
Гэр доргитол ёжтой хашгарав.
Авилгач нохойн сүрэг шиг тэд
Амаа цуцтал бардамнан хөөрөв.
Гедийн ордон нам гүм
Гэгээгүй шөнө ам жим
Шөнө дунд өнгөрсөн цагт
Шүлэг нойронд автагдсан үед
Эх орон, эхнэр нөхрөө
Энхрийлэх сэтгэл энд бадраад
Огторгуйн хоёр од буусан шиг
Огт алжаахгүй хоёр хүн сууна.
Энэ ертөнц цөм нойрссон ч
Эх орны тухай бодол бүү үүргэл!
Дэнгийн гэрэлд Гед ноён
Дэлгэр орныхоо тавиланг бодно.
Унгар эх нутагт минь
Өнөр жаргал заяагаасай.
Эх орон минь тавгүй бол
Эр нөхөр минь жаргалгүй гэж
Бурхан тэнгэрт даатган гуйж
Буян номын ихийг хийж
Хатан авгай зэргэлдээ өргөөнд
Хатамжлан залбирч мөргөнө.
Тэгж байтал сэлэм жадны
Тэрслүү чимээ чихнээ хадаж
Айсан хатан үсрэн босоод
Алагдсан хүн шиг зэвхий болоод
Эгшин зуур гүйн гараад
Эр нөхрийнхөө өрөөнд оров.
Энэхэн агшинд нөгөө хаалгаар

Эрэлхэг сэлэм гартаа атгаад
Ноён Комполти давшлан орж
Ноцтой гэгчээр Гедийг харж
“Сайн байна уу? Ноён Гед
Сааж зочлохоор ирлээ, бид
Гэнэт ингэж ирсэнд минь
Гэвч чи сандрав уу?
Яаж чухам орсонд минь
Яриангүй чи гайхав уу?
Хаалгачийг чинь хахуульдаж аваад
Хаалгыг чинь төвөггүй нээлээ.
Ширгэтлээ унтсан чиний цэргийг
Шилж авсан цэргүүд минь хүллээ.
Хайрлан харамлах хэрэг алга.
Хамаг юмаа өгч сал.
Өвч зэвсэгтэй зуун эр бий
Өөрөө итгэхгүй бол чи хар”
Ингэж хэлээд хаалга нээв.
Нов, Давид өмнө нь байв.
Үнэхээр цаана нь зуун цэрэг
Үүд сахин зогсож байв.
“Цөмийг юу хүссэнээ
Цөлмөж та нар ав.
Эрдэнэс баялаг хэрэггүй
Энэ юманд хахаж үхэг” гэж
Улайрсан дайсны зүг
Уурласан Гед хэлээд
“Хайрт чи минь ганц
Харж ханашгүй эрдэнэ
Айж зовох явдалгүй
Аварч би хамгаална.
Өргөө гэртээ ор гэж





Өөрийнхөө хатанд хэлэв.
Олон хулгайчаа Комполти дагуулж,
Онгилж уудлахаар ордоор тэнүүлж
Ах дүү хоёр л мэл гайхаад
Алхам ч хөдлөхгүй гөлрөн зогсож
Хэрцгий хоёр дээрэмчний
Хэл ам нь татсан байх,
Тэгээгүй бол ичгүүргүй
Тэсгэлгүй ингэж асууна байх
“Эгэл бидний зүүд үү?
Тив дэлхийн оронд
Тэнгэрийн дагина залраа юу?”
Тушаатай юм шиг хоёул
Туньж баахан зогссоноо
Эрхэм хатны өрөө рүү
Эгнэж гэнэт дайрлаа.
Эр нөхөр нь замыг нь
Эрсэлж чанд хаагаад
Ариун диваажингийн үүдийг
Нүгэлтнээс хамгаалан сахих шиг
Атгасан сэлмээ гялалзуулж
Нүүрээ барайлган зогсоод
“Ариун энэ хаалганд
Алхам ч ойртож болохгүй,
Нандин энэ үүд өөд
Наашилж ирж хэрэггүй
Өрсөлдөн тулахаас буцахгүй
Өөрөө үхэхээс буцахгүй
Үнэнч зарц би
Үүрд хамгаалж зогсоно.
Гэдрэгээ бушуу арил
Гэрээс бушуу тонил!” гэж

Шунасан хоёр яргачинд
Шууд зоримог өгүүлэв.
Шийдсэн хоёр гэвч
Ширвэж ер айсангүй.
Догдолсон үгийг нь ойшоосонгүй.
Догширсон харцыг нь таашаасангүй.
“Замыг минь чи хаагаад
Занаж сүрдүүлэх санаатай юу?
Ирт сэлэм хангинуулж
Эргүүлж буцаах бодолтой юу?
Зуун сэлэмтэй зогсож байсан ч
Зугтаж би зайлахгүй.
Нэвт дайраад гарна.
Зулбаж чи чадахгүй
Амь биеэ хамгаал
Алалдах тулаан хийе!” гэж
Уурласан Иов хашгирав.
Улангассан юм шиг догширов
Ир нь хавиралдаж сэлэм хангинаад
Хорвоо ертөнц хөмрөхийн адил
Хоёул тэд халз тулав.
Өөдгүй хүнд самбаанд гэгчээр
Өрсөх тулаан өрнөж байхад
Хажуухан талаар нь Давид өнгөрч
Хатны өрөөнд сэм оров.
Айж балмагдсан Перенна хатан
Амьгүй юм шиг ухаан алджээ.
Хүний гар дээр хөөрхийн бүсгүйн
Хүчир бачим бахирах нь сонсдов.
Хав харанхуй шөнийн дунд
Хамаг орчин дугжирсан үед
Хайначке шилтгээн ч бас нойрсжээ.



Харин ганц манаач л үлджээ.
Өнгөндөө манаач унтахгүйг хичээвч
Өөрийн эрхгүй нүд нь анилдана.
Дэвхдэх шахаж нүдээ нээгээд
Дэмий л бас ийш тийш ажна.
Аниргүй нам гүмийг гэнэт цочоон
Аймшигт чимээ чих дэлсэв.
Аажим аажим тодорсоор байв
Айсан манаач залбиран чагнав
Зүүд нойрны ид цагаар
Чөтгөр шулам босох нь энэ үү?
Зүрх нь түгшиж манаач ширтээд
Чөлөө завгүй хөндийг харуулдав.
Дээр тэнгэрээс саран авхай
Шаргал туяагаа шилтгээнд тусгав.
Дэргэд газраас цагаан манан
Цайвар өнгөөр бүрэлзэн тосов.
Сарны туяа, манан хоёр
Саатаж уулзсан амрагийн адил
Нийлж орхиод цацран тунана
Нилгэр хөндийг гэрэлтүүлж өгнө.
Гедеврээс Шалго орох замаар
Гэтэл нэг морьтон айсуй.
Тэр хүний гар дээр нь нэг бүсгүй
Тэврүүлж орхиод цуг айсуй
Сэвлэг үс нь сэгсийн хийсээд
Сэршгүй нойронд дарагдсан хүн шиг
Араас нь нэг морьтон довтлох нь
Анд шунасан хөх чоно шиг
Хоёр морьтон жирэлзэн өнгөрөх нь
Хоромхон зуурын зэрэглээ адил
Нозоорч ядраад амрахын цагт

Нойр сандаах зүүдийн адил
Эрхэмсэг олзоо нандигнан тэвэрсээр
Эрдэнэ шилтгээндээ Давид ирлээ.
Айж зовоод аяншиж ядраад
Авчирсан хүүхэн нь ухаангүй хэвтлээ.
Аяархан өргөөд зөөлөн орон дээр
Аваачиж тавиад олзны хүүхнээ
Ангаахай шувуу хулгайлсан хүүхэд шиг
Асарч Давид анхаарч тордов.
Үзэсгэлэн гуад нь сэтгэл уярч
Үргэлж дэргэд нь Давид зогсож
“Тэнгэрийн од шиг олон нүдийг
Тэтгэн ивээгч бурханд заяавал
Тэр бүгдээр чамайг л харахсан
Тэгээд ер харж ханахгүйсэн
Хэн гэгчийн үр вэ чи
Ингээд хараад байхад минь
Их л танил юм шиг
Хэзээ чамайг үзлээ дээ!
Аа тийм, сая л саналаа.
Аль дээр цагт уулзсан юм байна.
Шархтай зээр үзэхдээ өрөвдөж
Шаналан уйлдаг үе байжээ.
Бөглүү ойгоор өглөөнөөс аваад
Бүхэл өдөржин тэнэж байжээ.
Удтал хэсэж ядарч орхиод
Ургамал ногоон дээр зүүрмэглэж хэвтэхэд
Анхил үнэр чинь ариутган сэнгэнэж
Амраг чамтай би золгожээ.
Эрээн солонго газарт буух шиг
Эрхэм чи над руу тонгойж
Мөнгөлөг хоолой чинь цангинаж байхыг



Мөн л би зүүдэндээ үзжээ.
Тэвэрч авахаар гараас сунгаж
Тэгээд би сэрж билээ.
Тэртээ хол гялалзах төдий
Тэнгэрлэг чи минь арилж билээ.
Чиний хойноос уулын тийшээ
Чигээрээ би гүйж билээ.
Хан оройд нь арайхан гараад
Хадаатай юм шиг зогсож билээ.
Оройд нь хүршгүй оргил өндрөөс
Од адил гэрэлтэн туяарч
Чилтлээ зогсож гайхсан намайг
Чи тэгэхэд ширтэж билээ.
Өрөвдөх сэтгэлтэй бяцхан жаал
Өнөөдөр харин яргачин болжээ.
Усны урсгал шиг үгээ цувуулж
Удтал чамайг хүлээн зогсном.
Хөврүүлэх үгийг минь үл ойшоон
Хөшөө чулуу шиг чи хэвтнэм.
Урин хавар ирэхээ байгаад
Уран цэцэг ургахаа байг.
Ганцхан л чи минь сэргэж сэхвэл
Ганихарсан миний аз болог.
Ашгүй дээ, чи минь нүдээ нээлээ
Аргагүй дээ, бүр орчлон гийлээ
Хорвоогийн нар дээр, бас нэг нэмлээ
Хоёр нар хослон чимлээ.
Ингэж Давидыг уяран байхад
Иов гэнэтхэн дэргэд нь ирээд
“Боль доо, дүү минь боливол болж
Бод доо, одоо миний ээлж
Эрдэнэсийг хоёулаа олсон болохоор

Эдлэхдээ хоёулаа хуваана аа” гэв.
Энэхэн зуур Перенна хатан
Эргэн тойрон эрэн хайн
Алаг нүдээрээ ширтэн харав
Амраг нөхрөө дуудан очив.
“Эр нөхөр минь, орон гэр минь,
Энд алга, цөм хүнийх
Хар элэгтнийд шаналж байна, би
Хайрт эр минь хаана байна аа, чи?
Ондоо хүний дэргэд айж байна аа, би
Ор ганцаар минь битгий орхио, чи
Үнэнч чамайгаа хүлээж байна аа, би
Үгээ хэлээч, хаана байна аа чи?”
“Эр нөхөр чинь энгүй хол,
Эрслэн дэмий хүлээхээ боль,
Гуа сайхан чинь гутчих болно.
Гунхсан залуу нас өнгөрөх болно.
Дээд тэнгэрээс чамайг хулгайлж
Дэндүү ганцаараа тэр эдэлжээ.
Авралд минь орж биднийх бол
Аль сайхнаар чинь сэтгэлээ хангая” гэж
Балмад Иов бардам хэлэв.
Барьж ноцохоор ойртон ирэв.
“Булай амьтан цаашаа бол
Балай юм донгосохоо боль
Хилэнцэт нэг үгийн чинь төлөө
Хэмжээт нэг алхмын чинь төлөө
Өөрийн минь нөхөр эргэж ирээд
Өшөөг чамаас авна шүү!” гэж
Шунасан яргачныг эрслэн хараад
Шуударсан бүсгүй үгээ хэлэв.
Ёжилсон юм шиг муухай инээж



Иов өөдөөс нь ингэж хэлрүүн:
“Хэрэв үнэхээр нөхөр чинь ирвэл
Хэцүүхэн юм учирч мэднэ.
Даанч тэр алс оджээ.
Далдын далд арилаад өгчээ.
Энэ дэлхий маань лав түүнд
Элсний ширхэг шиг бүртийх вий.
Олон үг нурушаад ч яахав
Одоо тэр яаж ирэхэв.
Энэ сэлэмний цусыг хар
Эр нөхрийн чинь цус даа.
Өөрийнхөө гараар түүнийг би
Өргөн дэлхийгээс тонилгосон доо.
Үйлээ бардаг эрийн гинжнээс
Үүрд чи чөлөөлөгдөх нь энэ
Дөнгөж хоёр гар тэвэрч байснаа
Дөрвөн гар чамайг тэврэх боллоо.
Эрх дураа эдлэх чинь тэр” гэв.
Навчаа гэсэн өнчин хайлаас
Навсайсан цасанд даруулж орхиод
Хавсарган шөнө сүүдийн сүүмийх мэт
Хатан Перенна гиоүрэн гөлрөв.
Хайртынх нь цус толботон улайх
Халтай сэлмийг өшрөн ширтэв.
Үлгэн салган, үхсэн амьдын
Үлгэр зүүд шиг манан сарниж
Авсалсан мөсөнд дарагдсан гол шиг
Ариун сэтгэл нь оволзон эхлэв.
Хэнхдэг цээжээ зүрх нь балбаж
Хилэн, хорсол, гомдол нь бадарч
Галт уул дэлбэрэхийн адил
Гамшиг зовлон нь нэгмөсөн илэрч

Хараал зүхэл урсгаж гарав.
Хар хэлээ билүүдэн хурцлав.
Алуурчныг занасан гашуун үгс
Аманд багтамгүй асгаран цував.
Харин яргачин огт санаандгүй
Хараал зүхлийн мөндөрт балбуулж
Цэцгийн хураар умдаалах адил
Цээж дүүрэн баяртай зогсож
“Уурлаад ирэхээрээ чи ер нь
Учиртай сайхан болох юм.
Өдөр бүр чи гэрлээд
Өөрийн чинь нөхрийг би алаад
Хар толгойд хүрэх вий гэж халширч айхгүй
Хараалын чинь энэ мөрөн дунд
Ханатлаа шумбаж байх сан” гэв.
Хөөрхий Перенна Давидыг аргадаж
Хөлний нь өмнө цөхрөн сөгдөөд
“Адтай энэ ороолонг бодвол
Арай чи хүн ши залуу байна
Хэрэв хүсвэл сэтгэлээ өгье
Хэзээд үнэнч боол чинь больё
Эр нөхрийг минь алсан яргачнаас
Эвий намайг өмгөөлж аваач” гэв.
Энхрий бүсгүйг элгэндээ тэврээд
Эрс чангаар Давид өгүүлрүүн:
“Зүггүй багын минь зүүдний уяа
Зүрхний хайрт чамайгаа өмгөөлье.
Хурмастын ариун дагина чиний
Хуяг, бамбай би больё.
Аварч чамайг хамгаалахын төлөө
Амиа солихоос бүү буцъя.
Ах Иов, чи ч гэсэн



Анхаарч үүнийг сайн бод” гэв.
Хоромхон төдийд Иов догширч
Хоёр нүдээ гялалзуулан өчихдөө
“Хэзээд олзоо хуваана гэж
Хэлэлцэж тохирсон биш үү
Эмс хүүхнийг хамаагүй гэж
Эрээгүй чи бодно уу.
Эр нөхрийг нь тонилгосон
Ирт сэлэм энэ байна.
Нээрэн чи хүсвэл
Нэгийгээ үзэх ёс байна.
Хоёулаа тулж эхлэх үү?
Хоорондоо эсвэл эвлэх үү?”
Ултай будлианаа таслахыг
Иртэй сэлмэндээ даатгаад
Ах, дүү хоёр тэгээд
Амь солихоор шийдээд
Хэн хэнээ хялайж
Хэрсэн бух шиг зогстол
“Аядаарай, аядаарай” гэсээр
Аав нь орж ирлээ,
“Хэний нь зөв болохыг
Хянан болгоож өгнө үү?
Олзны хүүхнийг хуваахгүй гэж
Онгирч дүү давшлав.
Олсон бүгдээ хуваах
Онцгой ёсонд нийцэх үү,
Аль би буруу юу” гэж
Аваасаа Иов асуув.
Аав нь тэднийг зэмлэж
Аашилж ийн хэлрүүн:
“Хэрэггүй дэмий юман дээр

Хэрүүл зодоон тарина уу?
Ашиггүй балай юман дээр
Аавыгаа шүүгч болгоно уу.
За, яая гэх вэ дээ.
Заргыг чинь таслахаас биш дээ.
Хээрийн энэ олзыг
Хэнд чинь ч би өгөхгүй
Өөдгүй будлианыг дарж
Өөрөө би авъя” гэв.
Балмагдсан хоёр хүү
Барьсан, сэлмээ алдав.
Аянганд өртсөн ус
Амсраа даван цалгих шиг
Нүгэлт хүвүүдийн цус
Нүүр өөдөө харвал
“Ноён Комполти тушаасан хойно
Номхон дагавал зохино” гэж
Амандаа бувтнасан хоёрыг
Аав нь сүрхий зандрав.
Эвий хөөрхий Переннаг
Эгшин зуур нэрвэсэн
Зүйргүй зовлонг тэвчдэг
Зүрх мөн бөх өө!
Тансаг ордонд хоригдоод
Тав, зургаа хонолоо.
Зовсон нэг мөч
Зуун жил шиг удна.
Эр нөхрөө мөрөөднө.
Эсвэл айн сүрдэнэ.
Бузар яргачнаас өшөө авахаар
Бултаж зайлахыг бодно.
Олон санаа санавч





Оргож зайлах газаргүй
Элдвээр шаналж байтал
Эзэн Комполти орж ирээд
“Далдын хүч чамайг
Дагаад байдаг юм байна
Зүгээр чамайг харах бүр
Зүрх сэтгэл догдолж байна
Эхнэрээ болгож авна даа” гэж
Эрээ цээргүй өгүүлэв.
Эрхэмсэг Комполти чиний
Эцэслэх цаг болжээ гэж
Эрлэгийн элч шивнэх шиг
“Эхнэр чинь би болъё” гэж
Зовсон бүсгүй ам өгч
Зөнөсөн өвгөн баярлаж
Дараа нь Перенна хүүхэн
Давидыг сэм дуудаад
“Үнэхээр намайг хайрлах
Үүрдийн сэтгэл гэдэг чинь
Төөнөсөн гал шиг үнэнч үү?
Төөрсөн гал шиг хуурамч уу?
Хэзээд сэтгэлтэй хэвээр гэж
Хэлж чи чадах уу” гэв.
“Урсгал түргэн гол
Уруу газраа дурлах шиг
Өндөр тэнгэрийн од
Өөд газраа хүсэх шиг
Атигар бяцхан шавьж
Амтат бүрэлзгэнэд шунах шиг
Энхрий бүсгүй чамд
Энэ бие минь татагдана
Хайрын оволзсон сэтгэлээ

Хангах арга байна уу?” гэж
Залуу хүү өөдөөс нь
Залгаж яруу асуув.
“Арга гэвэл ч байна л даа!
Аварч намайг ав л даа!
Ах чинь нөхрийг минь алсан
Аав чинь надтай суух гэсэн
Этгээд хоёрыг л хөнөөвөл
Энэ бие минь чинийх
Өршөөж намайгаа хамгаал” гэж
Өчиж Перенна өгүүлэв.
Хайр сэтгэл, хайр сэтгэл
Хачин тайлшгүй оньсого чи
Хүний зүрх гэдэг
Хүчит нэг булгаас
Ариун цэцгийн сайхныг
Аль муухай бургтыг
Гол мөрөн шиг л
Гуд урсгаад явчих юм.
Хайр сэтгэл, хайр сэтгэл
Хачин тайлшгүй оньсого чи
Гатлаад гаршгүй өргөн
Ёроолд нь хүршгүй гүн
Гадаад их далай гэгч
Ёстой чи мөн.
Тэнгэрийн од цөмийг тольдсон
Тэнгис адил чи уужим
Аварга гэж чамайг хэлэхгүй
Аврагаас аврага гэж чамайг хэлнэ”
Тамын бузар амьтад ч
Талцан өрсөн тулж
Ганцхан чамаас болоод



Гавлаа хуваалцдагийг харав уу.
Хайр сэтгэл чи
Хамгаас илүү эрхтэй.
Хайр сэтгэл чи
Бүгдээс илүү хүчтэй.
Эгэл жирийн хүнийг чи
Эрхэм тэнгэр болгох юм.
Эрхэм тэнгэр өөрийг нь
Буг шулам болгох юм.
Буг шулам өөрийн нь
Хүн төрх олгох юм.
Онц тунгалаг нам гүм шөнө
Одон титэмт саран авгай
Алтан дэлхийг тайван ширтэнэ.
Ажиг сэжиггүй бэдрэн явна.
Аавыгаа, ахыгаа энэ дэлхий дээр
Алж байгаа хүн байх л юм.
Эцэг өвгөдийнхөө нойрсох өрөөнд
Эрээн могой шиг Давид ороод
Чичирсэн гараар хөшгийг нь сөхөж
Чилээрхэж амарсан аавыгаа хараад
“Сэрүүн цагтаа шулмын адил
Сэхүүн хэрцгий байдаг сан билээ.
Төлөв номхон хүний адил
Төв төвшин нойрссон ажээ, шулмын
Эсвэл хүүгийн сэтгэл дагаад
Эцэг минь ийм зөөлөн харагдана уу?
Хүүгийн сэтгэл ааваа өрөвдөж
Хүсэшгүй зочин болон залравч
Шийдсэн зоригоос би няцахгүй
Шинжгүй хэргээс би буцахгүй”
Эгшин зуур ингэж бодоод

Эцгийгээ Давид багалзуурдан авав.
Амьсгал нь цухалдаж хэд өндөсхийгээд
Аав нь тэгээд нам болов.
Айсаар Давид хөшгийг нь хаагаад
Арайхийж үүдний тушаа ирээд
Амь орохгүй байгаа гэж эмээвч
Ахиад хөшиг нээж зүрхэлсэнгүй.
Сандарсан Давид гүйн очоод
Санаандгүй нойрссон Иовыг сэрээж
Өрсөж босохын самбаа өгөлгүй
Өлгөөтэй хутгыг нь цээжинд нь зоов.
Ах нь гэвч дороо үхсэнгүй.
Арайхийж босоод ганхсаар дөхөв.
Тулахыг нь хүлээлгүй сэлмээ сугалж
Духан дундуур Давид цавчив.
Улаан цус асгаран урсаж
Ухаангүй Иов газар унав.
Сэхээ намбаагүй Давид айж
Сэлмээ хаяад зугтан гүйж
Ороолон шулманд хөөгдсөн юм шиг
Орох газраа олж ядав.
Хаалганы ард орж зогсоод
Хар дарж нүдээ анив.
Алаг нүдээ хичнээн анивч
Аав ах хоёр нь илхэн үзэгдэв.
Цонхийж зэвийсэн аав нь харагдана.
Цусанд будагдсан ах нь харагдана.
Хоёулаа хилэгнэж өөрийг нь дайрах шиг
Хорон хумсаа биед нь шигтгэх шиг
Ухаан нь балартаад Давид унав.
Утдал тэр шалан дээр хэвтэв.
Уужраад харвал гэгээ оржээ.



Урд талд нь эцэг нь байжээ.
Мэдрэлгүй хүүрийг Давид харж
Мэдээгүй юм шиг ийн асуув:
“Аав минь, чи одоо босооч
Аян дайнд хөдлөхөө бодооч
Эзэн хаангүй манай улс
Эх толгойгоо алдсан байна шүү!
Энэхэн далимыг нь ашиглан хөдөлье.
Эрчлэн дайрч Гедийг сүйтгэе.
Хамаг юмыг нь чи аваарай.
Хатны нь харин над өгөөрэй.
Таг нойрноо дугжраа юу?
Таалал төгсч өнгөрөө юу?
Хожмын өдөр шүүхийн өмнө
Хонзон санаж намайг зэмлүүзэй.
Сэхэшгүй нойрссоны минь буруутан гэж
Сэжиглэн чи намайг ховлуузай.
Өөр тасалгаанд Давид ороход
Өмнө нь бас Иов хэвтэв.
Хөшсөн биеийг нь хөлөөрөө хөдөлгөн
Хөрсөн сэтгэлээр ингэж өгүүлэв.
“Энэ чинь одоо хэн бэ?
Ээ, яасан хүн бэ?
Ах Иов биш үү?
Аяа тэр мөн үү?
Хатуу члуун шалан дээр
Хажуу хавирга чинь чилэхгүй.
Яасан бөх хүн бэ!
Ямар боргил эр вэ!
Ах минь, одоо босооч
Арилга наадах цусаа
Өнөөдөр та нар босохгүй

Өнжинө гэж хэлэлцээ юу?
Тэгэх тусмаа сайн
Тэнгэрлэг хайртаа аваад
Эндээс даруй холдье” гэж
Элий балай Давид гарав.
“Алчихав уу, тэднийг” гэж
Амдаж Перенна асуухад:
“Үгүй, үгүй, алаагүй,
Үйлсгүй хэрэг хийгээгүй.
Нэг нь зэвийж цайчихаад
Нөгөө нь барайж улайчихаад
Огт хөдлөхгүй тэр хоёр
Ойрхон энд нойрсож байна.
Тэд биднийг харахгүй
Тэгэвч яаралгүй болохгүй.
Оргил цамхаг дээр гаръя
Онгон тэнгэр өөд нисье” гэв.
“Ай бурхан минь галзуурчихжээ” гэж
Айсан бүсгүй хашгараад
Булзаж гарахыг мэрийвч
Бултаж зайлахыг оролдовч
Өнөөх гайхал Давид
Өргөж аваад гүйлээ.
Олон шатыг дамжиж
Олон шатыг авирлаа.
Айсан бүсгүй хашгарав.
Алмайрсан залуу аргадав.
“Чимээгүй бай, хайрт минь
Цаадуулыгаа сэрээчихнэ.
Баригдаж гарт нь орвол
Баларч үхэх нь тэр
Одоохон хоёул нисье” гэж





Онцолж Давид хэлээд
Элгэндээ Переннагаа тэврээд
Эгц цамхгийн оройгоос
Гүн жалгын ёроол руу
Хүч мэдэн үсэрлээ.
Уулын хад жалгын ногоо
Улаан туяагаар цацарлаа.
Ёрдойх ордны ёроолд
Ёс төр болсонгүй.
Давид Перенна хоёр
Дуг нойрондоо оржээ.
Аав, ах хоёр нь ч
Анхныхаа байранд хэвтэнэ.
Ямбатан тэр дээдсийн
Ясыг барих хүн олдсонгүй.
Тэдний удам ингээд
Тив дэлхийд үлдсэнгүй.
Үлдсэн хөрөнгийг хуваахдаа
Үймсэн барлагууд нүдэлдэж
Алагдсан нь шөнийн од шиг
Амьд нь өдрийн од шиг
Хогийн хүүрэн дээгүүр нь
Хон хэрээ эргэлдэнэ.
Эртний шилтгээн Шалго
Элэгдэн элэгдэн өмхөрчээ.
Доор нь орших хүмүүс
Догшин сайхнаас айсуу.



Ц.Хасбаатарын орчуулга

НАМРЫН ХУУЧААР

Уудам хөндийн цэцэг гандаж
Улиангар модны навчис унасаар
Уйтгарт өвлийн элч ирж
Уул нуруу цасанд хучигдлаа.
Зориг сэтгэлд минь ид хавраараа
Золбоо хийморь минь халуун зунаараа
Нас минь хэдий залуу ч гэсэн
Үс минь одоо цайж эхэллээ.
Анхилуун цэцэг гандан муудаж
Амьд бүхэн үхэн нөгчдөг.
Өршөөлт гэргий минь наашаа ир
Өвдөг дээр минь эрхлэн суу.
Гэнэт маргааш нас барвал минь
Гиншиж гашуудаж уйлах уу, чи.
Яахын эрхгүй ингээд үхчихвэл
Ясыг минь тэгээд барилцах уу, чи.
Өөр хүнд сэтгэлтэй болчихвол
Өчүүхэн намайгаа мартчихгүй биз дээ? чи
Гашуудлын алчуураа нөмрөхөө боливол
Булшин дээр минь аваачиж өлгөөрэй.
Би тэгвэл авснаасаа босоод
Бэлбэсэн эмийн тэр нөмрөгийг
Харанхуй шөнө сэмхэн аваад
Хар нүхэндээ эргэж ороод
Нүднийхээ нулимсыг арчина
Зүрхнийхээ шархыг бооно, түүгээр
Ямар амархан мартаав дээ гэж
Яасан ч тэгээд муу санахгүй.





Ц.Хасбаатарын орчуулга

ӨНӨ САЙХАН ЭХ ОРОН МИНЬ ӨНДИЙН БОСОХ ЦАГ БОЛЛОО

Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Аль хэдийн тахиа дуугараад
Ариун өглөө эхэлснийг зарлалаа.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Хурмаст тэнгэрт нар мандаад
Хурц гэрэл нүүрийг чинь төөнөөд
Хорыг чинь хөдөлгөж байна шүү.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Хадгалсан тарианд болжмор цуглараад
Ханатал идэн жиргэлдэж байна.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Хулгайч муур сүү уучихаад
Хушуу амаа долоож байна.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Мал сүрэг зоргоороо бэлчээд
Манай тариаланг гишгэчиж байна.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Усан үзэм гандан муудаад
Улс амьтан сандарч байна.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!

Хөрш айлынхан газраа хагалаад
Хөрст газраас минь хумсалж байна.
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Хиншүү үнэртэж халуу оргиод...
Хэнгэрэг дэлдэхийг дуулав уу, чи
Өнөр сайхан эх орон минь
Өндийн босох цаг боллоо!
Унгар нутаг минь, эх орон минь
Унтсаар байгаад мөхөх гэж үү?
Магад ч үгүй... бүү мэд!





Ц.Хасбаатарын орчуулга

НОХОЙН ДУУ

Бургаж бүрхсэн алсад
Өвлийн шуурга исгэрнэ.
Бороо цас холилдож
Нүд чихгүй шуурна.

Сайн эзний ачаар
Санаж бодох юмгүй.
Галын өрөөний буланд
Гайгүй дулаан хэвтэнэ.

Эзэн их иддэг болохоор
Идшинд зовох юм алга.
Эзний хоолны тавганд
Эрхбиш шавруу үлдэнэ.

Ташуур л ганцхан бэрх дээ
Тас гэхтэй нь зэрэг уйлна.
Ноцтой сүрхий янгинавч,
Нохойн яс бөх юм.

Эзэн ноён маань зөөлрөөд
Хөөрхийлж намайг дуудна.
Эрхэлж өмнө нь ойчоод
Хөлийг нь долоож баясна.



Ц.Хасбаатарын орчуулга

1848 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН 15

Унгарын түүхийн билэгт тэнгэр
Урам зоригтой бичиж эхлээч
Хүлээсэн өдөр хүрээд ирлээ
Хүссэн их явдлыг тэмдэглээч.

Энэ хэдхэн хоногийн дотор
Эрт дээр цагаас аваад
Эцэг өвгөдийн тэмцээд олоогүй
Эрхэм сайхан амжилтанд хүрлээ.

Бодол минь минь жигүүрээ дэлгээ
Боол байснаа больсоон, чи
Эрх дураараа эрэмцэн тэмүүл
Энх огторгуйд дүүлэн нис.

Хэцүү хүнд зовлонгийн дундуур
Хэдэн зуун жилийн туршид
Эмгэнэн хөөрхийлж хайрласаар ирсэн
Эх нутгийнхаа дээгүүр нис.

Хэвлэх, нийтлэх чөлөөтэй боллоо.
Хэзээний мөрөөдөл минь сая л бүтлээ.
Улс маань сэргэж зүрх нь цохиллоо.
Унтрах мөхөхийн аюулаас аврагдлаа.

Арслан зоригт Пештын залуусын
Алдар гавьяа мандан бадарлаа.
Өсөх насны хатан зоригоор
Өвч нутгаа эдгээж авлаа.



Эрхтэн дээдэс хурал хийж
Эх адаггүй яриа дэлгэж
Аанай л шуугиж байх үеэр нь
Ардын хөдөлгөөн хотод эхэллээ.

Санаснаа хэлэх ариун эрхийг
Саатуулж хорьсоор өдий боллоо.
Цогтой залуус зориглон орцгоо
Цоож гинжийг нь тас цохицгоо.

Дайсан гэнэт халдвал яана
Дажгүй аяндаа учир нь олдоно.
Гав гинжинд дахин орсноос
Голт зүрхээ жадлуулсан нь дээр.

Эрэлхэг залуус тулаад орцгоо
Эрх чөлөөгөө тэмцэн олцгоо
Ариун омгоо бадраан дүрэлзүүлж
Атаат дайсантай нэгийгээ үзэлцье.

Сайн санаат олныхоо ачаар
Саад бүхнийг ялан давж
Нүүрэндээ галтай дайрлаа, бид
Нүдэндээ цогтой дайтлаа, бид.

Санаснаа хэлэх бидний уриаг
Саатуулж хориглож хэн ч чадахгүй.
Хэлэх ярих чөлөөтэй боллоо
Хэвлэх, нийтлэх эрхтэй боллоо.

Эрчлэн тэмүүлсээр Будад очиход
Эх нутгийнхаа зовлонгийн тухай
Эрэмгий зоригтой хэллээ гэж
Эрхэм зохиолчийг хорьсон байлаа.

Насан өндөр Будын оройд
Начин шонхрууд нисэн хүрэхэд
Хатан зоригтны аяыг даахгүй
Хадан хавчиг чичигнэж хөдөллөө.

Хөөрхий зохиолчийг бид суллаж
Хөх тэнгэрийн бараа харуулж
Матяшаас хойш манай орон
Магад ингэж баярлаагүй биз.

Унгарын түүхийн хамаг явдлыг
Уулын хаданд сийлэх хэрэгтэй.
Аугаа гайхамшигт ялалтын тухай
Ачийн ач нар маань уншиж яваг.

Омогдож гайхуулж чаддагсан бол
Одоо л нэг бардах юмсан
Энэ хэргий чинь би толгойлж
Эрэлхэг залуусыг уриалсан юм шүү.

Ашдын ерөөлт энэ өдөр л
Амь нас минь үүрд мөнхөрлөө!
Агуу их Наполеонтой ч гэсэн
Алдар нэрээ би солихгүйеэ!

